

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2008-2012 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

2009.12.20

Чойр хот

| №  | Бодлогын зорилт, арга хэмжээ  | Биелэлт  | Хувь |
|--|---|--|------|
| <b>НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГАА</b>  |   |  |      |
| <b>ЗОРИЛТ:</b> <i>Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй, өндөр хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр-иргэний итгэлцэлийг бэхжүүлэх.</i> |   |  |      |
| 1  | <p>1.1.1. Төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлэн, авлига, хээл хахуультай тууштай тэмцэж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.</p>   | <p>Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар аймаг сум, багийн Засаг дарга, түүний ажлын албаныхан, зарим агентлагт сургалт зохион байгуулж Төрийн албан хаагчийг иргэдэд үйлчлэх сэтгэлгээнд онцгой өөрчлөлт гаргахыг зорилоо. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн Засаг даргын удирдах шуурхай зөвлөгөөний дэг, журмыг шинэчлэн баталж оролцогсодын хариуцлагыг тодорхой болгож мөрдөж байна. Төрийн үйлчилгээг шуурхай хүнд сурталгүй болгоход өнгөрсөн жил илүү анхаарч ажиллалаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс албад сар бүр 1 суманд “Иргэдтэй ажиллах нээлттэй өдөрлөг”-ийг зохион байгуулж байна. Аймгийн Засаг дарга энэ өдөрлөгөөр болон 3 дахь өдөр бүр иргэдийг хүлээн авч уулзан, Төрийн байгууллагууд Пүрэв гараг бүр тусгай хуваарийн дагуу радиогийн шууд ярилцлагад оролцож иргэдийн санаа бодлыг сонсож, тавьсан хүсэлтийг судалж зохих арга хэмжээг авч хэвшлээ. Сумд байгууллагууд үйлчилгээний чиглэл, хариуцах эзэн, дүрэм журмаа иргэдэд ойлгомжтой хэлбэрээр ил тавьж гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэж байна</p> <p>Нэг цонхны үйлчилгээний байрыг засварлан ашиглалтад оруулж ажлын гурван өдөр ажиллаж байсныг иргэдийн хүсэлтээр аймгийн Засаг даргын захирамжаар ажлын таван өдөр 10<sup>00</sup>-16<sup>00</sup> цагийн хооронд Хөдөлмөр халамжийн үйлчилгээ, Нийгмийн даатгалын үйлчилгээ, Худалдаа үйлчилгээ, Газрын харилцааны үйлчилгээ, 3-р багийн Засаг дарга, Улсын бүртгэлийн үйлчилгээ, Мэдээлэл лавлагаа, Нотариатын үйлчилгээ, Хаан банк гэсэн 9 төрлийн үйлчилгээ үзүүлэн хэвийн үйл ажиллагаагаа явуулж хэвшээд байна.</p> <p>“Нэг цонхны үйлчилгээ” нээгдсэнээр иргэд төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой болж, иргэд талархалтай байна.</p> | 50.0 |
| 2  | <p>1.1.2. Мэргэжлийн ур чадвартай, дадлага туршлагатай, үнэнч шударга, өндөр боловсрол, ёс суртахуунтай, төрийн захиргааны мэргэшсэн чадварлаг албыг төлөвшүүлж, нутгийн удирдлагын байгууллагуудын нэгдмэл байдал, залгамж чанарыг бэхжүүлнэ</p> | <p>Төрийн байгууллага бүр Төрийн албан хаагчдыг чадваржуулах “Сургалт” хөтөлбөртэй болсон. Аймгийн Засаг даргын Тамгын газар албан хаагчдаа туршлагажуулж тогтвортой ажиллуулах зорилгоор ажлын үр дүнг харгалзан 5 жил тутамд урамшуулал олгож байхаар шийдвэрлэсэн. Тухайн албан тушаалыг хашихад дутагдах мэдлэгийг ажлын байран дээр олгох сургалтыг олон хэлбэрээр явуулж байна. Хүн тус бүрээр сургалтын хэрэгцээг гаргаж байна. Энэ хугацаанд ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж байна. Аймгийн Засаг дарга ИТХуралтай байнга ажлаа зөвлөж шаардлагатай зарим асуудлыг ИТХурлын Тэргүүлэгчид Засаг даргын зөвлөл хамтран хэлэлцэж шийдвэрлэж байна. Аймгийн Засаг дарга улиран томилогдон ажиллаж байгаа тул үйл ажиллагаа уламжлагдан төрийн залгамж чанар бэхжиж байна. Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай Батламж байгуулж, түүнийг хэрэгжүүлэх арга зүй, анхаарах асуудлын талаар сургалт хийж гарын авлага бэлтгэж өгөв.</p> <p>Сумдын ЗДТГазрынхан, Багийн Засаг дарга нарт Засгийн газар болон аймгийн Засаг</p>  | 50.0 |

|   |  |  |      |
|---|--|--|------|
|   |  | <p>даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сэдэвт 2 хоногийн сургалтыг зохион байгуулав.</p> <p>Төрийн захиргааны албан тушаалд хууль зөрчин түр томилогдон ажиллаж байсан 42 албан хаагчийг чөлөөлж, Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг ажиллуулж байна. Хөдөөгийн багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл бололцоогоор хангах үүднээс хөдөөгийн багийн төвүүдийг засварлан шинэчлэх, багийн хэсгийн ахлагч нар, багийн сахиулуудын урамшуулалыг нэмэгдүүлэх саналыг 2010 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаад байна.</p>   |      |
| 3 | <p>1.1.3. Төр, иргэний нийгэм /ТББ/, аж ахуйн нэгж, байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, түншлэлийн харилцааг өргөжүүлэн, төрийн зарим чиг үүргийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэн үр дүнг тооцно.</p> | <p>Төр иргэний нийгэм, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг өргөжүүлэх зорилготой “Түншлэл 2009” зөвлөлгөөнийг Мерси Кор ОУ-ын хөтөлбөрийн газартай хамтран зохион байгуулсан. Түншлэлийн хүрээнд Аймгийн Төр-иргэний нийгэм-бизнесийн байгууллагын түншлэл анхдугаар зөвлөгөөн, “Аймгийн иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийн үнэлгээ”, “Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу”, “Түншлэл ба олон нийтийн оролцоо”, “Орон нутагт олон талт түншлэлийг хөгжүүлэх”, “Төрийн бараа ажил үйлчилгээг нээлттэй ил тод, өрсөлдөөнтэй болгох арга замууд, төрийн зарим чиг үүргийг ИНБ-ууд, бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх боломжууд”, ИНБ-уудад зориулсан “Иргэдийн хэрэгцээнд тулгуурласан төслийн санал боловсруулах”сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, “Цэвэр сайхан орчин хог” төсөл хэрэгжүүлэв.</p> <p>Мөн Багануур дүүргийн төрийн байгууллагуудад төсвөө нээлттэй болгох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж амжилттай хэрэгжүүлсэн “Шилэн түрийвч” төслийн үйл ажиллагаатай танилцаж, Аймгийн ИТХурлын дарга төрийн бус байгууллагынхантай 2 удаа уулзалт ярилцага зохион байгуулж, мэдээлэл солилцлоо.</p> <p>Засгийн газрын 2009 оны 213 дугаар тогтоолын 4 дэх заалтаар тухайн орон нутгаас болон бусад аймаг, хотын чиглэлд хийх зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулах асуудлыг “Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Тээвэр автозамын газарт шилжүүлж, зохицуулалтын орлогыг тус агентлагт үлдээж байхаар шийдвэрлэсэн. Энэ дагуу Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас санаачлан хот хоорондын такси үйлчилгээнд явдаг жолоочтой уулзалт зохион байгуулж, тэдэнд төрийн үйлчилгээний талаар тодорхой мэдээлэл өгч, нэгдсэн зохион байгуулалтад оруулж албан ёсны зөвшөөрөл олгохоор боллоо.</p> | 30.0 |
| 4 | <p>1.1.4. Багийн ажиллах нөхцөлийг сайжруулж, төрийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, сум бүрийг жишиг багтай болгоно.</p>   | <p>Төрийн анхан шатны үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх үүднээс “Баг” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сум бүрийг жишиг багтай болгохоор ажиллаж байна. Багийн ажиллах нөхцлийг сайжруулах үүднээс хөдөөгийн 6 багийг унаажуулж, албан тасалгааг тохижууллаа.</p> <p>Сумдын ЗДТГазрынхан, Багийн Засаг дарга нарт Засгийн газар болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сэдэвт 2 хоногийн сургалтыг зохион байгуулав..</p> <p>Хөдөөгийн багийн Засаг дарга нарын ажиллах нөхцөл бололцоогоор хангах үүднээс хөдөөгийн багийн төвүүдийг засварлан шинэчлэх, багийн хэсгийн ахлагч нар, багийн сахиулуудын урамшуулалыг нэмэгдүүлэх саналыг 2010 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаад байна.</p>   | 30.0 |
| 5 | <p>1.1.5. Бүртгэлийн үйл ажиллагаанд мэдээллийн цахим хэлбэрийг нэвтрүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр ханган төр,</p>   | <p>Засгийн газрын тогтоолоор Улсын бүртгэлийн албыг байгуулан үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Хүн амын мэдээллийг программд оруулаад байна.</p>   | 30.0 |

|   |  |  |      |
|---|--|--|------|
|   | иргэнийг холбосон бүртгэлийн төгөлдөршлийг хэрэгжүүлнэ.  |  |      |
| 6 | 1.1.6. Гамшигаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох ажлыг зохион байгуулан, шаардлагатай техник хэрэгслээр хангаж, барилга байгууламжийг шинэчлэн, гамшиг, ослоос хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлнэ.   | Гамшигаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох ажлын эхлэлийг Баянтал сумаас эхэлж 1 хоногийн сургалтыг амжилттай зохион байгуулав. Уг сургалтын үйл ажиллагаанд аймгийн холбогдох мэргэжлийн байгууллагууд, сумдын удирдлага Баянтал сумын 5 байгууллага 250 гаруй иргэд оролцсон байна. Сүмбэр суманд команд штабын иш бүрэн сургуулийг зохион байгууллаа.  | 30.0 |
| 7 | 1.1.7. Хил залгаа болон бусад улсуудын муж хотуудтай байнгын харилцаа тогтоож, тогтвортой хамтран ажиллах чиглэл баримтална  | Хил Залгаа болон бусад улсуудын муж хотууд болох Хятад улсын Эрээн хот, Буриад улсын Бичурн райоин, Казакстан, Герман зэрэг улсуудтай хөдөө аж ахуй, байгаль орчин, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах талаар харилцаа холбоо тогтоож эхлээд байна<br>Зүүн хойд Азийн орнуудын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож аймгийн танилцуулга материал болон зарим онцлог үйл явдлыг нийгэмлэгийн вэб сайтад тавьж аймаг орныг сурталчилж байна.<br>Энэ хугацаанд Хятадын Хэнан мужид зохион байгуулагдсан “Аялал жуулчлаын дэд хороог байгуулах” хуралд 3 хүн , Солонгосын Пухан хотод зохион байгуулагдсан “Эдийн засгийн зөвлөгөөн.”-д 1 хүн тус тус оролцуулсан.<br>Оросын холбооны элчин сайд, Герман улсын элчин сайдын яамтай харилцаа тогтоож МСҮТ, ЭМГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.<br>Монгол улсын гадаад харилцааг эдийн засагжуулах нь үндэсний хөтөлбөрт аймгийн нийгэм эдийн засгийг гадаад хамтын ажиллагаагаар хөгжүүлэх 3 саналыг тусгуулаад байна.   | 30.0 |
| 8 | 1.1.8. орон нутагт хэрэгжиж байгаа Өвсний үндэс, Жайка, Койка, FTI. JCS. Юнеско, Юнисеф, Айфо, Боловсролын хөгжлийн хөтөлбөр болон Дэлхийн зон ОУБ, Mercy corps төслийн газар гэх мэт олон улсын төсөл ,хөтөлбөрийн байгууллагуудтай хуулийн хүрээнд хамтран ажиллана. | Орон нутагт хэрэгжиж байгаа Дэлхийн Зөн ОУБ, Мэрсис кор, Тогтвортой амьжиргаа II зэрэг хөтөлбөр төслийн газруудтай хуулийн хүрээнд хамтран ажиллаж сумдын цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын газар, багийн эмчийн унаа, сургуулийн урлаг заалны гэрэлтүүлэгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн.<br>Mercy corps байгууллагын зүгээс 2009 оны 8-р сарын Малчны "Говийн нүнжиг" холбооны малчдаас махны нийлүүлэлтийг аймгийн МСҮТ-ийн оюутны дотуур байрны гуанзтай холбож өгснөөр сардаа 750-850 мянган төгрөгийн мах нийлүүлж байна.<br>"Говьсүмбэр - 2009" үзэсгэлэн худалдаа, ИНБ-ууд, төрийн байгууллага, , Мерси Кор-ын төлөөлөлүүд оролцсон чөлөөт ярилцлага, “Төрийн захиргаанаас Нийтийн захиргаа руу” сургалт зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.<br>Азийн хөгжлийн банкны 150.000 ам долларын хөрөнгөөр санхүүжигдэх “Гэр хороололыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх” төслийг Сүмбэр сумын гэр хороололд хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан 2 ажилтныг сонгон шалгаруулах ажлыг зохион байгууллаа. Сонгон шалгаруулалтад оролцсон 20-оод хүний материалыг Азийн хөгжлийн банкинд хүргүүлснээр М.Хулан, О.Мөнх-Эрдэнэ нарыг шалгаруулсан байна.<br>Хүрээ Ротари клубээс “300 эмэгтэйд хавдрын шинжилгээ хийх” ажлыг орон нутагт амжилттай зохион байгуулсан. Цаашид аймгийн төвийн хүн амын ундны усыг цэвэршүүлэх талаар хамтран ажиллахаар хүсэлт тавьсан. | 50.0 |
| 9 | 1.1.9. Төсөл, хөтөлбөрийн байгууллагатай хамтарч аймгийн эдийн засаг, нийгмийн нарийвчилсан суурь судалгааг хийж, орон нутгийнхаа ирээдүйн хөгжлийн гарцыг тодорхойлно   | 1998-2021 оныг хүртэлх аймгийг хөгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.<br>Аймгийн эдийн засаг, нийгмийн нарийвчилсан суурь судалгааг “Мэрсис кор” ОУ-ын байгууллагатай хамтран хийх саналыг тавиад байна.<br>Хугацаа болоогүй   |      |

| 2. Эрх зүй |   |   |      |
|------------|---|---|------|
| 10         | 1.2.1. Хөтөлбөр бодлого боловсруулах, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах явцыг нээлттэй болгож, аль болох ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн санаа бодолд тулгуурлан шийдвэрлэж хэвшинэ.                                     | Нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах явцыг Нээлттэй болгох, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа тал болон иргэдийн саналд тулгуурлах бодлого барин ажиллаж, энэ хүрээнд 1 захирамжинд Нээлттэй санал авч боловсруулан гаргаж мөрдүүлэхээр бэлтгээд байна.<br>Иргэдийн саналд тулгуурлан аймгийн баяр наадмыг аймгийн төвд хийсэн. Тендертэй холбоотой сөрөг үзэгдлүүдийн талаар иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхнээс санал гарсны дагуу орон нутагт тендерийг орон нутгийн бизнес эрхэлдэг байгууллагуудаар гүйцэтгүүлэх аймгийн Засаг даргын 2009 оны 9 сарын 14-нд А/315 тоот захирамж гаргасан. Энэ шийдвэрийн үр дүнд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 500 оюутны ажлын хувцсыг аймгийн оёдолчид, Үдийн цай хөтөлбөрийг аймгийн компани, албан хэргийн материалыг Бизнес дэмжих компани, барилгын засвар үйлчилгээг орон нутгийн компаниуд хийж гүйцэтгээд байна. Энэ олон талын арга хэмжээнд иргэдийн сэтгэл ханамж өндөр байгаа.  | 10.0 |
| 11         | 1.2.2. Иргэдэд эрх зүйн боловсрол олгох албан бус сургалтын хүртээмж, чанар, үр нөлөөг дээшлүүлэх хуулийн боловсролыг иргэн бүрт олгох анхан шатны сургалт, сурталчилгааг эрчимжүүлж хуулийн хүрээнд амьдарч хуулиа дээдлэх үзлийг төлөвшүүлнэ. | Нутаг дэвсгэрийн хүрээнд эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааг зохион байгуулж иргэдийн эрх зүйн ухамсрыг нь төлөвшүүлэх, эрх зүйн боловсролыг нь дээшлүүлэх зорилгын хүрээнд <ul style="list-style-type: none"> <li>➢ Иргэдийн дунд</li> <li>➢ Байгууллага аж ахуйн нэгжүүдэд</li> <li>➢ Төрийн албан хаагчдад</li> <li>➢ Салбараар гэх мэт төрөлжүүлэн,</li> </ul> Улаанбаатар хотоос багш урих, үе шаттай сургалт явуулж, үр дүнг нь АХА, Дэвжээ, центавр зэрэг тэмцээн, асуулт хариулт ярилцлага зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж байна. Нийт 33 удаа 56 сэдвээр 2000 гаруй хүнийг хамруулсан. Сургалтанд өөрсдийн боловсруулж, бэлтгэн гаргасан нийт 13 төрлийн, Хууль зүй дотоод хэргийн яам, “Хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба хүний эрх” төслийн газраас ирүүлсэн, зарим тохиолдолд төрийн бус байгууллага “Хүний эрхийн үндэсний комисс”, “Хүйсийн тэгш эрхийн төв”, “Хүний эрх хөгжил төв”-үүдээс авсан тараах материалуудыг ашиглаж байна. Эрх зүйн сурталчилгааг Эрх зүйн туслалцааны төв, Нэг цэгийн үйлчилгээ, удирдах ажилтнуудад 14 хоногт 1 удаа, сар бүр сумдадаа зохион байгуулдаг Нээлттэй хаалганы өдөрлөг, хөдөөгийн багаар аяладаг Аялах хайрцаг /3200 гаруй /зэргээр гарын авлага материалаа тараах, санал асуулга авах хэлбэрээр явуулж байна. Нийт 4000 гаруй иргэнд гарын авлага материал тараасан байна. Сүмбэр сумын 3 багийн нийт 79 иргэнд Иргэдийн эрх зүйн хөтөч номын дагуу 3 удаагийн эрх зүйн албан бус сургалт зохион байгууллаа. Эрх зүйн туслалцааны төвөөс төлбөрийн чадваргүй 20 иргэний 18 хэрэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлж 13 хэргийг шийдвэрлэсэн байна. | 30,0 |
| 12         | 1.2.3. Хууль тогтоомж, УИХ, Засгийн газар, нутгийн удирдлагын бүх шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг тууштай хэрэгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж үр дүнг тооцож ажиллана  | Засгийн газар, нутгийн удирдлагаас гарсан шийдвэр орон нутагт тууштай хэрэгжүүлэх үүднээс Засгийн газрын тогтоол шийдвэр, Үндэсний хөтөлбөрүүд, аймгийн ИТХ, Засаг даргын шийдвэрийг тухай бүрд хяналтад авч холбогдох хэлтэс албадад эзэнжүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. Иргэдэд зориулсан сургалт сурталчилгаа, мэдээллийг тогтмолжуулж, Говьсүмбэрийн мэдээ сонинд 14 хоног тутамд мэдээлэл өгч, Эрдэнэсийн гайхамшиг FM радиод 7 хоног бүр хуваарийн дагуу иргэдийн санал хүсэлтийг авч ярилцлага зохион байгуулж тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаанд тусгаж байна. Мөн   | 30.0 |

|    |   |  |      |
|----|---|--|------|
|    |   | Архидалттай тэмцэх, архины хор хөнөөлийг сурталчилсан эрүүл аж төрөхүй нэвтрүүлгүүдийг өдөр бүр явуулж байна.  |      |
| 13 | 1.2.4. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ, зөвлөгөөг Эрх зүйн туслалцааны төвтэй хамтран үзүүлж, төрийн зарим үйлчилгээнүүдийг нэг цэгээс үзүүлдэг болно.   | “Эрх зүйн туслалцааны төв” нь 2009 онд 580 хүнд үйлчилгээ үзүүлснээс эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нийт 18 хэрэгт 20 хүнтэй өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах үндсэн нөхцлийг бүрдүүлж ажиллалаа. Эрх зүйн сургалт сурталчилгааны ажилтан 48 иргэн 14 байгууллагад анхан шатны зөвлөлгөө, мэдээллээр үйлчилсэн.  | 50.0 |
| 14 | 1.2.5. Цагдаагийн хэлтсийн ажиллах нөхцлийг сайжруулж, боловсон хүчнээр бэхжүүлж, техник тоног төхөөрөмжийг шинэчилж, гадаад дотоодын сургалтад хамруулж, цагдаагийн ёс зүйг дээшлүүлнэ.  | Цагдаагийн хэлтсийн ажиллах нөхцлийг сайжруулж, аж ахуйн аргаар хүлээх заал, жижүүрийн албаны өргөтгөлийн барилга барьж, агуулахын зориулалтаар ашиглаж байсан барилгыг их засвар хийн тохижуулж, хурлын заал, алжаал тайлах өрөө, цайны газар болгон ашиглаж байна. Цагдаагийн албан хаагчдын дунд өдөр бүр ёс журмын эргүүл ажиллуулж, дотоодын хяналт, шалгалтыг чангатгаснаар сахилгын арга хэмжээ, авагдсан алба хаагчдын тоо жил бүр буурч байна. 2009 онд дотоодод 19, гадаадад 1 алба хаагч мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдлаа.   | 50.0 |
| 15 | 1.2.6. Архидан согтуурахтай тууштай тэмцэх Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол ихсэх хандлагатай байгаа нөхцөл байдлыг харгалзан цагдаагийн постыг тогтмол ажиллуулна. Авто замын арчлалт хамгаалалт, тэмдэгжүүлэлтийг иж бүрэн хийнэ.                                 | Архидан согтуурахтай явдалтай тэмцэх чиглэлээр 2 нэгдсэн, 8 хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, хууль бусаар гар дээрээс согтууруулах ундааны зүйл бусдад худалдсан зөрчил 12 илрүүлж, 245000 төгрөгний торгууль оногдуулан, эрүүл ахуй стандартын шаардлага хангаагүй 320 литр архи спирт, 60 литр архи, 78 литр гар аргаар үйлдвэрлэсэн бараашиг нэртэй согтууруулах ундааны зүйл худалдсан “Сүмбэр шанд” хүнсний дэлгүүрийг 150000 төгрөгөөр торгосон байна. Архи согтууруулах удаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгох комиссыг шинэчлэн цаашид тоог нэмэхгүй байх бодлого барьж ажиллаж байна. Архидалттай тэмцэх, архины хор хөнөөлийг сурталчилсан, эрүүл аж төрөхүй нэвтрүүлгүүдийг өдөр бүр явуулж байна. Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх үндсэн чиглэл, төвөлгөө боловсруулан хэрэгжүүлж, 70 хувийн биелэлттэй байна. 12 сарын 10-нд Архидалтын эсрэг хамтдаа зөвлөгөөн зохион байгуулж, архинд хамааралтай иргэд, тэдний гэр бүлийнхэнд Архидалт мансуурлын эсрэг ТББ-га болон хууль хяналтын байгууллагууд илтгэл тавьж, сургалт явууллаа. Цагдаагийн ерөнхий газарт асуудал тавьж замын цагдаагийн зохицуулагчийн орон тоог нэмэгдүүлснээр 24 цагийн байнгын ажиллагаатай постыг ажиллуулж байна. ЗХАБЭ гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад 8 гарч 2-оор буюу 40.0, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон байдал 123 буюу 38-аар 23.6% тус тус буурсан. 2009 онд замын тэмдэгжүүлэлтэнд зориулан замын сангаас 5 сая төгрөг зарцууллаа. Цагдаагийн хэлтэст 5.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, Замын цагдаагийн постны орчим автомат хаалт, замын хажуугийн зогсоол, гэрэлтүүлэг зэрэг тохижилтийн ажлуудыг эхлээд байна. | 50.0 |
| 16 | 1.2.7. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хүрээнд малчдын бүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлж, хил залгаа аймгуудтай бүсийн зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж, үр дүнг тооцон мэдээллийн сантай болно. Сайн дурын хөдөлгөөнт эргүүлийг үйл ажиллагааг дэмжинэ. | 2009 оны 2 дугаар сард аймгийн “Сайн малчдын зөвлөлгөөн”-ийг хийж малчдын бүлэг холбоог дэмжих, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах талаар уриалга гаргасан ба энэ үеэр малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх санд 2.4 сая төгрөгний хандивыг малчдаас өгсөн. Цагдаагийн ерөнхий газраас, ирсэн үүргийн дагуу алдуул малын нэгдсэн сантай болж эхлээд байна. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх талаар хил залгаа аймгуудын цагдаагийн байгууллагатай мэдээ, мэдээлэл солилцон хамтран ажиллаж байна. Сумдад Малчдын бүлгийн тоо өсч идэвхитэй үйл ажиллагаа явуулж эхлэсэн. Эдгээр бүлгүүдтэй хамтран сайн дурын хөдөлгөөнт эргүүлүүд гаргах ажил эхлээд байна.   | 30.0 |
| 17 | 1.2.8. Монгол Улсад мөрдөгдөж байгаа  | Давхардсан тоогоор үзлэг шалгалтанд 655 аж ахуйн нэгж, байгууллага, 9800 иргэн   | 50.0 |

|   |  |  |      |
|---|--|--|------|
|   | стандартын төвшинд хүрсэн үйлчилгээг иргэдэд хүргэхэд хяналт, шалгалтын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.  | хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 126 албан шаардлага үйлдэж, биелэлтийг хангуулав. Хууль, стандартын шаардлага хангаагүй 2216.8 мянган төгрөгийн эд зүйлийг улсын орлого болгож, 1526.1 мянган төгрөгийн эд зүйлийг устгасан байна.   |      |
| <b>Хоёр. НИЙГМИЙН БОДЛОГО</b>   |  |  |      |
| <b>ЗОРИЛТ:</b> Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай байх нөхцөлийг бүрдүүлнэ. |  |  |      |
| 1. Боловсрол  |  |  |      |
| 18  | 2.1.1. Боловсролыг нийгмийн тэргүүлэх чиглэл, ирээдүйн хэрэгцээ шаардлага гэж үзэн оюуны, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж, иргэдийн оюуны чадамжийг дэмжих урамшууллын механизмыг бий болгоно. Бичиг үсгийн боловсрол олгох шаардлагатай иргэдийг албан бус, дүйцсэн болон хувилбарт сургалтад хамруулан боловсрол олгоно. | Ерөнхий боловсролын 4 сургуульд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг эрхэлж бичиг үсэг үл мэдэгч 11-15 насны 10 хүүхдийг бичиг үсгийн сургалтанд хамруулснаас 8 нь бичиг үсэг тайлагдсан. Боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 120 суралцагч хамрагдснаас суурь боловсролыг 15-24 насны 12, бүрэн дунд боловсролыг 17-оос дээш насны 37 иргэд төгсөж суурь боловсролын гэрчилгээ бүрэн дунд боловсролын үнэмлэх гардан авч хүн амын боловсролын хэрэгцээг хангах сургалтанд 71 иргэн хамрагдснаас 27 иргэн амьдрах ухааны, сургалтад хамрагдсан байна.  | 30,0 |
| 19  | 2.1.2. ЕБС-ийн дотуур байранд тохилог орчин бүрдүүлж хамрагдвал зохих хүүхдийг бүрэн хамруулна.  | “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд Баянтал сумын ашиглагдахгүй байсан барилгын нэг орцыг их засварын ажлаар “Гурван хажинга трейд” ХХК гүйцэтгэж 60 хүүхдийн шинэ дотуур байрыг ашиглалтад орууллаа. Шинээр ашиглалтад орж буй дотуур байрны тоног төхөөрөмж, хүүхдийн ор, хэрэглэл, соёлын танхимын иж бүрэн хэрэглэгдэхүүнийг “Тогтвортой амьжиргаа II” төслийн хүрээнд нийлүүлж 9,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ. Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 60 хүүхдийн хүчин чадал бүхий дотуур байрны ор, хэрэглэлийг сайжруулахаар “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд 4.9 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлж орыг шинэчлэн модон ороор хангаж, цагаан хэрэглэл, хөнжил, гудсыг бүтнээр шинэчлэн сольсноор хүүхдийн амьдрах эрх хангагдаж тохилог, тав тухтай орчин нөхцөл бүрдлээ. Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 40 хүүхдийн хүчин чадал бүхий дотуур байрны гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэхээр “Тогтвортой амьжиргаа” төслийн хүрээнд 6.3 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл хэрэгжүүлж 1, 2-р хоолны тогоо, шарах шүүгээ, аяга, таваг ариутгагч, махны машин, хөргөгч, гурил зуурагч, бууз жигнэгч зэрэг төхөөрөмжөөр хангасан нь дотуур байрны хүүхдийн хоолны эрүүл ахуйн болон ариун цэврийн орчны шаардлага хангагдаж, амт чанартай хоол, хүнсний бүтээгдэхүүнээр хангагдах нөхцөл бүрдлээ. | 70,0 |
| 20  | 2.1.3. ЕБС-ийн 6 настай хүүхдийн суралцах орчинг бүрэн бүрдүүлж багш, сурагч, эцэг эхийн хамтын бүтээлч санаачлагыг дэмжин *Багш-сурагч-эцэг эх* гэсэн гурвалсан холбоог шинэ түвшинд гаргана.   | ЕБС-ийн 6 настай хүүхдийн нас сэтгэцийн онцлог тохирсон эрүүл ахуйн шаардлага хангасан сургалтын орчин бүрдүүлэхийн тулд “6 настай хүүхдийн суралцах таатай орчин бүрдүүлж, боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх нь” сэдэвт уралдааныг хичээлийн жилийн турш зохион байгуулан дүгнэж, гарсан ололт амжилт, алдаа дутагдалд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. 2009-2010 оны хичээлийн жилд 4 сургуулийн 10 бүлэгт 6 настай 235 хүүхэд суралцаж байна. Сургалтын орчин мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. *Багш-сурагч-эцэг эх*-ийн хариуцлагын гэрээг байгуулж ажиллаж байна.   | 50,0 |
| 21  | 2.1.4. Боловсролын салбарыг хөгжүүлэх 2007-2010 оны дунд хугацааны төлөвлөгөөг бүрэн   | Монгол Улсын Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн боловсролыг салбарыг 2007-2010 онд хөгжүүлэх дунд хугацааны  | 30,0 |

|    |   |   |      |
|----|---|---|------|
|    | хэрэгжүүлж, 2010-2015 оны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ. Багшлах боловсон хүчнийг чадваржуулж, чанаржуулна.  | төлөвлөгөөний эхний шат болох 2007-2008 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гарган аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлээ. Тус аймгийн Боловсролын байгууллагууд нь мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. Энэ онд Сургагч багш бэлтгэх сургалтад 4 багш, онлайн сургалтад 28, вакуумжуулсан сургалтад 10 багш тус тус хамрагдлаа.<br>Аймгийн ЕБС-ийн нийт багш нарын 11.5 хувь нь тэргүүлэх, 25.4 хувь нь заах аргач мэргэжлийн зэрэгтэй.  |      |
| 22 | 2.1.5. Сургууль, цэцэрлэг, СӨБ-ын уялдааг сайжруулж, 2012 онд СӨБ-ын хамран сургалтыг 99.0, цэцэрлэгийн хамран сургалтыг 70.0, суурь боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ.  | Сургуулийн өмнөх боловсрол болон бага, дунд боловсролын агуулга арга зүйн залгамж холбоог сайжруулах тал дээр хамтран ажилласнаар цэцэрлэгт хамрагдвал зохих 1225 хүүхдээс, 849 хүүхэд хамрагдаж, 69.8 хувь буюу өмнөх оноос 10.2 хувиар, СӨБ-д хамрагдах хүүхдийн хамран сургалт 83.5 хувиар буюу 13.3 хувиар нэмэгдэж, Суурь боловсролын хамран сургалт 100 хувьтай байна.  | 50,0 |
| 23 | 2.1.6. Төрийн бус өмчид суурилсан сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах санал, санаачлагыг дэмжиж, боловсролын салбарт өрсөлдөөн бий болгоно.   | Төрийн бус өмчид суурилсан “Буян” хувийн цэцэрлэгийг дэмжиж төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хувьсах зардлаас хоолны зардал болон цалингийн санг олгож байна. Буян цэцэрлэгийн дэргэд 20 хүүхэдтэй Яслийн бүлгийг шинээр нээж нийт 83 хүүхэд тус цэцэрлэгт хүмүүжиж байна. Төрийн бус өмчид суурилсан “Буян” хувийн цэцэрлэгийг дэмжиж төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хувьсах зардлаас хоолны зардал болон цалингийн санг олгож байна. Цаашид иргэдийн санал санаачлагыг дэмжих арга хэмжээ авч байна.  | 50,0 |
| 24 | 2.1.7. Аймгийн төвд 100 хүүхдийн цэцэрлэг, яслийн цогцолбор, 640 хүүхдийн хичээлийн барилгыг ашиглалтанд оруулна.   | Сүмбэр сумын 100 хүүхдийн цэцэрлэг-яслийн цогцолборын барилга угсралтын ажлын дуусгалтын тооцоог гаргаж экспертизээр батлуулснаар гүйцэтгээгүй ажлын 216,0 сая төгрөгт нэмэлт гэрээ байгуулан Дэлхийн зөн ОУБ-ын 40 мянган ам долларын санхүүжилтээр барилгын ажлыг үргэлжлүүлж байна. Сүмбэр сумын 640 хүүхдийн хичээлийн байрыг 2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бариулахаар болоод байна.  | 30,0 |
| 25 | 2.1.8. Баянтал сумын ЕБС болон цэцэрлэгийн байрны нөхцлийг сайжруулан, сургалтын тоног төхөөрөмжийг шинэчилнэ.  | Баянтал сумын 4-р сургуулийн хичээлийн байр, барилгыг шинээр засварлах ажлыг “Бүх нийтийн боловсролын түншлэл” хөтөлбөрийн хүрээнд болон гамшигаас хамгаалах сангийн 20 сая, улсын төсвийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засварлав.  | 70.0 |
| 26 | 2.1.9. Шивээговь сумын Цэцэрлэгийн барилгыг өргөтгөнө.  | Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” хөтөлбөр барилгын зураг төслөө хүргүүлэн эхний шатны үнэлгээнд орж тэнцсэн ба дараагийн шалгаруулалтанд орохоор хүлээгдэж байна.<br>Цэцэрлэгийн барилгыг гамшгаас хамгаалах сан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засварлаж, 2009-2010 хичээлийн жилд ашиглалтанд орууллаа.<br>Шинэ Цэцэрлэгийг “Тогтвортой амжиргаа” төслийн хүрээнд тоглоомоор бүрэн хангаад байна.  | 10.0 |
| 27 | 2.1.10. Мэргэжил Сургалт Үйлдвэрлэлийн Төвийн мэргэжлийн чиглэлийг олшруулж, Европын хамтын ажиллагааны нийгэмлэг, Мянган хөгжлийн сорилтын сангийн сургалтын төсөлд хамруулан шинэ техник, технологи лабораторитой болж загвар сургууль болгон, элсэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | 2009 онд Хүнд машин механизмын техник-операторч болон уул уурхайн цахилгаан механик мэргэжлээр нийт 128 хүнд мэргэжил эзэмшүүллээ.<br>МСС-иас зохион байгуулсан “Төр, хувийн хэвшлийн нийгмийн түншлэл” сэдэвт бүсчилсэн сургалт-семинарт хамрагдан тус төслийн хүрээнд хэрэгжих МСҮТ-ийн чадавхийг бэхжүүлэх 150 мянган ам.долларын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах эрхийн төлөө өрсөлдөж байна.<br>Мөн “Оюу толгой” төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай уул уурхайн мэргэжилтэй ажилтан бэлтгэх загвар сургуулийн эрхийн төлөө 10 сургуультай өрсөлдөн тус эрхийн хүрээнд 100 мянган ам .долларын тэтгэлэг авах болзлыг хангаад байна. | 70.0 |

|                      |  |  |      |
|----------------------|--|--|------|
|                      |  | БСШУЯ-наас 2009-2010 оны хичээлийн жилд өмнө бэлтгэж байсан 6 мэргэжил дээр нэмж 7 мэргэжлээр сургалт явуулах эрхийг нэмж аваад, 650 хүүхдийн хяналтын тоо батлуулан хичээллэж байна.<br>ДЗОУБ-ын "Бор-Өндөр 2" ОНХХ-ийн хүрээнд эксковатор 315, Д7 бульдозер болон оюутны дотуур байрыг иж бүрэн тохижуулаад байна.   |      |
| 28                   | 2.1.11. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн багш нарын 70 хувийг мэргэжлийн ур чадвар, зэргийн түвшинг дээшлүүлэх сургалтанд хамруулж, 40-оос доошгүй хувийг магистрын зэрэгтэй болгон, шаталсан сургалттай уул, уурхай барилгын чиглэлийн коллеж болох бэлтгэл ажлыг хангана. | Багшлах боловсон хүчний мэргэжлийн ур чадвар, зэргийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр 5 багшийг магистрын сургалтанд хамруулаад байна. Мөн БСШУЯ, Мянганы сорилтын сангийн төсөл хөтөлбөрийн хүрээнд 7 багшийг мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтанд хамруулсан.<br>Уул уурхайн зөвлөх инженер 1, магистр цолтой 2 багшийг нэмж ажилд авсан. Нийт багш нарын 30 хувь магистр зэрэгтэй болоод байна.   | 50.0 |
| 29                   | 2.1.12. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд урлаг, спортын заалыг Дэлхийн зөн ОУ-ын байгууллагын хөтөлбөр төслийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулна.  | ДЗОУБ-ийн 2010 оны төсөвт МСҮТ-д урлаг, спортын заал барих хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Бор-Өндөр ОНХХ-т хүсэлт тавиад байна.   | 10.0 |
| 30                   | 2.1.13. Төсөл хөтөлбөрийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр иргэний боловсролыг дээшлүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.   | Америкийн Засгийн газрын хөрөнгө оруулалттай "СЕЕВТС Евро-Ази" хөтөлбөр Говьсүмбэр аймгийн 2-р сургууль дээр хэрэгжиж байна. 2009-04-18-22-нд Нью-Йорк мужийн 2 багш туршлага судлахаар тус аймагт ирсэн. АНУ-ын Засгийн газрын хөрөнгө оруулалттай иргэний боловсрол төвийн санхүүжилтээр "Иргэн" төсөл хэрэгжиж байна. Аймгийн хэмжээнд 30 гаруй багш сургагч багшаар бэлтгэгдэж аймгийн сурагчдын дунд Иргэн төслийн цомог шалгаруулах уралдаан зохион байгуулж 6 багш ахлан оролцлоо. 2009-2010 оны хичээлийн жилд Иргэний боловсролын хичээлийн хөтөлбөрийг нийгмийн ухааны багш нар хамтран боловсруулж туршиж эхлээд байна. | 30,0 |
| 31                   | 2.1.14. Сургууль цэцэрлэгийн эрүүл ахуйн орчинг сайжруулах төсөв хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж хэвшүүлнэ.   | Сургууль, цэцэрлэгийн эрүүл ахуйн орчинг сайжруулах талаар хийх ажлыг сургууль цэцэрлэгийн ажлын төлөвлөгөөнд тусгуулаад байна.  | 10.0 |
| 32                   | 2.1.15. Дэлхийн зөн олон улсын байгууллагын үйл ажиллагааг Шивээговь, Баянтал суманд хүргэн хүрээг өргөжүүлнэ.   | Шивээговь, Баянтал суманд Дэлхийн зөн ОУ-ын байгууллагын салбар нээх саналыг төв байгууллагад нь хүргүүлсэн.<br>Хугацаа болоогүй   |      |
| 33                   | 2.1.16. Сургуулиудын номын санг тохижуулж, номын фондыг нэмэгдүүлнэ.   | Аймгийн ЕБС-ын номын сангуудын номын фондыг Дэлхийн сонгодог утга зохиолын шилдэг 50 боть, бүрэн дунд сургуулийн түвшинд унших уран зохиолын 5 боть нийт 55 нэрийн 500.0 мянган төгрөгийн номоор тус тус баяжуулсан. 2009-2010 оны хичээлийн жилд ЕБС-ийн Номын сангуудад 19 төрлийн 3294 сурах бичгээр хангаж, номын фондыг нэмэгдүүллээ.   | 30,0 |
| <b>2. Соёл урлаг</b> |  |  |      |
| 34                   | 2.2.1 Аймгийн Боржигин чуулгыг орчин үеийн театр, чуулгын хэмжээнд хүргэж, мэргэжлийн уран бүтээлчдээр хангаж, нийгмийн асуудалд нь дэмжлэг үзүүлнэ.   | Мэргэжлийн урлагийн байгууллагын гол шалгуур үзүүлэлт болох уран бүтээлийн чанар, өөрийн орлогын бүрдүүлэлт, мэргэжлийн уран бүтээлчийн тоо, удирдлагын менежмент, хөгжмийн зэмсгийн хангалт, тоног төхөөрөмжийн хангалт сайжирсан. . Чуулга нь уран сайхны зөвлөлийг мэргэжлийн багш нараар бүрдүүлж ажилласан. 40 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд 5 хүнийг орон сууцны зээлд хамруулан байр олгоод байна.   | 50,0 |



|    |  |   |      |
|----|--|---|------|
| 35 | 2.2.2. Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн соёлын үйлчилгээг үзүүлэх, Боржигон чуулгыг шинэ байртай болгоно.  | Иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн соёлын үйлчилгээг үзүүлж хөрш аймгуудын театр, чуулгатай хамтарсан болон өөрийн аймаг, сумдад бие даасан тоглолтуудыг хийсэн. Үүнд: “Бодончир сэцэн “ дуулалт жүжиг, “ “Шашин урлагийн цэнгүүн “, “ Нар зөвийн эх орон “ тоглолтыг Дорноговь аймгийн “Саран хөхөө “ театрын хамт олонтой, Дундговь аймгийн Төв халхын дуулалт жүжгийн театр, “Хүүхдийн төлөө за гэж хэлцгээе” бие даасан хандивын тоглолт, “ Аймшигт анчин Пандуухайн паян “ хүүхдийн шинэ дуулалт жүжгийг олон түмэнд хүргэлээ. Чуулгын барилгын зураг төсвийг хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдүүлэхээр холбогдох газруудад санал тавиад байна   | 50.0 |
| 36 | 2.2.3. Нийтийн номын сангийн фонд, музейн үзмэр, үзүүлэгийг нэмэгдүүлж, стандартын шаардлага хангасан байртай болгож, иргэдэд үзүүлэх үйлчилгээг тогтмолжуулна.    | Аймгийн Нийтийн номын сан өөрийн фондод байгаа номыг ном зүйн ангилалд оруулж, нийт номын 8 хувийг зураасан кодоор коджуулж, уншигчийг соронзон картыг нэвтрүүлэн үйлчилж, цахим номын сангаар үйлчилж байна. Үндэсний номын сан, Япон улсын хандиваар 661 төрлийн 25 000 гаруй номоор аймгийн Төв номын сан, болон Шивээговь, Баянтал сумын номын сангийн фондыг баяжууллаа. Аймгийн музей 2009 онд <b>иргэдийн</b> гар дээр хадгалагдаж байсан 107, шинээр 29 үзмэр худалдан авч фондоо баяжуулснаар 641 үзмэрийн сантай болоод байна. Орон нутгийн төсвийн 15,4 сая төгрөгийн төсвөөр Аймгийн Музей, Нийтийн номын сангийн зураг төсвийг хийлгэсэн. 2010 онд Соёл хөгжүүлэх сангийн хөрөнгөөр барилгын ажлыг эхлүүлэхээр болоод байна.   | 50.0 |
| 37 | 2.2.4. Сумдын соёлын төв, орон нутгийг судлах танхимыг тохижуулж, номын сангуудад цахим үйлчилгээг нэвтрүүлнэ  | Шивээговь сумын Соёлын төвийн дэргэдэх орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг эхлүүлж төрийн болон төрийн бус байгууллага сурталчлах буланг байгуулсан. Иргэдийн гар дээрх үнэт эдлэл, өлгийн зүйлсийг бүртгэл мэдээллийн сандаа бүртгэж аваад байна. Соёлын төв нь номын сангийн фондоо 10.0 мянган номоор баяжуулж, үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж байна. Хөдөөгийн малчид болон 21, 22-р зөрлөгийн иргэдэд явуулын номын сангийн үйлчилгээг үзүүлж байна. Баянтал сумын Соёлын төвд орон нутаг судлах танхимыг байгуулж иргэдийн гар дээр байгаа түүх соёлын дурсгалт зүйлсээр Боржигин ахуй үзэсгэлэн гаргаж иргэдэд үйлчилж өөрсдийн гар доорх материалаар үзмэрийн фондыг баяжуулсан. 3-р улиралын байдлаар 300 гаруй иргэд орон нутаг судлах танхимаар үйлчлүүлсэн. | 50.0 |
| 38 | 2.2.5. Боржигины түүх, соёлын өв, зан заншлыг хамгаалан, сэргээн засварлаж, дотоод, гадаадад сурталчилан, ЕБС-ийн орон нутаг судлалын хичээлийн программд оруулах. | Улаанбаатар хотод 2009 онд зохиогдсон үзмэр шилжүүлэх үзэсгэлэнгээс 114 үзмэрээр фондоо баяжуулж, ерөнхий бүртгэлд бүртгэн, бүртгэлжүүлээ. Иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа үзмэрийн судлагааг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ЗДТГ, БСГазартай хамтран “Өв соёл-2009” үзэсгэлэн зохион байгуулж Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдын 21 иргэний гар дээр хадгалагдаж байгаа 153 үзмэрээр үзэсгэлэн гаргаж “түүх, соёлын өв тээгч” батламж хадгалууллаа. 2009-2010 жилийн хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн Орон нутаг судлалын хичээлийн программд Боржигин судлалын хичээлийг орууллаа.   | 30.0 |
| 39 | 2.2.6. Орон нутаг дахь хувийн хэвшлийн үүсгэл санаачлагыг дэмжиж орон нутгийн радио, хэвлэл мэдээлэл, телевизтэй болно   | Аймгийн хэмжээнд Боржигин EM-107.5, Эрдэнэсийн гайхамшиг FM- 102,5 богино долгионы радио ажиллаж байна. Говь-Сүмбэрийн мэдээ сонинг тогтмолжуулж 13 дугаар гаргаж , ТВ-9, Монцамэгийн орон нутаг дахь сурвалжлагчийг ажиллуулж иргэдэд мэдээ мэдээллийг шуурхай хүргэх арга хэмжээ авч байна . Энэ онд багтаан орон нутгийн телевизийг байгуулах төсөл хэрэгжүүлж байна.  | 30.0 |

3.Эрүүл мэнд, биеийн тамир спорт

|    |   |   |      |
|----|---|---|------|
| 40 | 2.3.1 Эрүүл мэндийн байгууллагуудын ажилтнуудын ёс зүй, харилцааны соёл, ажлын хариуцлага, түргэн шуурхай байдлыг сайжруулан үйлчилгээний хүнд суртлыг арилгана.  | Эрүүл мэндийн яамнаас 2009 оныг ёс зүй хариуцлагыг дээшлүүлэх жил болгон зарласантай холбогдуулан ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг 81 хувьтай тооцон ажиллаж, Эмч эмнэлгийн ажилтнуудын ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлэх сургалтыг хөтөлбөрийн дагуу явуулж хэвшив. Эмнэлгийн ажилтнууд болон үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч дүгнэлт хийн , Бүх эрүүл мэндийн байгууллагуудад “Ил тод байдлыг илтгэх үзүүлэлт”-үүдийг хүргүүлээд байна. Ёс зүй, харилцааны соёл, ажлын хариуцлага алдсан 2-3 их эмч нарт арга хэмжээ авсан.                             | 30.0 |
| 41 | 2.3.2. Нийгмийн даатгал, халамжийн байгууллагатай хамтран иргэдийг даатгалд хамрагдах хувийг нэмэгдүүлж, эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.                       | Аймгийн хэмжээнд хүн амын 70 гаруй хувь нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаад байна. Аймгийн нийгмийн даатгалд хамрагсадын хүрээ өнгөрсөн оноос ажил олгогч 8, заавал даатгуулагч 81 , сайн дурын даатгуулагч 82, багийн засаг дарга нартай гэрээ байгуулан ажилласаны үр дүнд эрүүл мэндийн даатгалд 264 малчин , ЭМД-ын төрөөс хариуцдаг даатгуулагчдын тоо 1297, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдээс даатгуулагчийн тоо 1648 хүнээр тус тус нэмэгдэж , 34.8 сая төгрөгийг төсөвт оруулсан . Цаашид даатгалгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажил үргэлжлэн хийгдэнэ. | 70.0 |
| 42 | 2.3.3. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг өргөтгөн үйлчлүүлэгчдийн тав тухтай орчинг бүрдүүлж, лаборатори, мэс заслын багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.          | Манай аймгийн хэмжээнд төрөлт нэмэгдэж байгаатай холбогдуулан ЭМЯ-тай зөвшилцсөний үндсэн дээр 10 ортой Амаржих газрыг шинээр барьж ашиглатанд оруулахаар 2010 оны Засгийн газрын үндсэн чиглэлд тусгуулан батлуулахаар болоод байна. ЭМЯ-ны 30 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нэгдсэн эмнэлгийн төрөх, мэс заслын тасгийг засварласан.<br>Ажлын байран дээрээ орчин үеийн техник хэрэгслийг ашиглан алсын зайны сургалтаар мэдлэг чадвар эзэмших шинэ мэдээ мэдээллээр хангагдах эхлэл тавигдаж байна<br>Эрүүл мэндийн газар интернетэд холбогдсон.                               | 30.0 |
| 43 | 2.3.4. Яаралтай тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан, Эрүүл мэндийн үйлчилгээний стандартын түвшинг хангана.   | Холбогдох мэргэжилтнүүдийг сургалтанд хамруулан яаралтай тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр анхааран нэгдсэн эмнэлгийн стандартыг ханган ажиллаж байна. Энэ онд нийт 5619 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч 100 хувь гүйцэтгэсэн. Томуугийн цар тахалтай холбогдуулан түргэн тусламжийн үйлчилгээ болон эмч нарын багийг өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллуулав.   | 70.0 |
| 44 | 2.3.5. “Цахим эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, алсын зайн оношлогоо, цахим картын тогтолцоог бий болгоно.   | Ажлын байран дээрээ орчин үеийн техник хэрэгслийг ашиглан алсын зайны сургалтаар мэдлэг чадвар эзэмших шинэ мэдээ мэдээллээр хангагдах эхлэл тавигдаж байна.<br>Эрүүл мэндийн газар интернетэд холбогдсон.хөрөнгө дутагдалтайн улмаас алсын зайн оношлогоо,цахим картанд холбогдож чадаагүй.ЭМЯ-наас түр хүлээх үүрэг өгөгдсөн.   | 30.0 |
| 45 | 2.3.6. Нарийн мэргэжлийн эмч нарыг гадаад, дотоодын давтан сургалтанд хамруулж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай хүний нөөцөөр бүрэн хангаж тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. | Нарийн мэргэжил олгох сургалтанд 4 их эмч,мэргэжил дээшлүүлэх сургалтанд 2 их эмч гадаадад нэг их эмч хэлний бэлтгэлд тус тус хамрагдаад байна.Сумдын эмнэлгүүд боловсон хүчнээр бүрэн хангагдсан.<br>Өрхийн эмнэлгийг эмчээр хангах,тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр анхаарч нийгмийн асуудал болон урамшуулалд зориулж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2 сая төгрөг олгохоор төлөвлөн, унаагаар хангаад байна.   | 50.0 |
| 46 | 2.3.7 Баянтал сумын эмнэлгийг зориулалтын байртай болгож, Шивээговь сумын эмнэлгийн барилгад их засвар хийнэ.   | Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын эмнэлэгт 10 сая төгрөгийн төсөв бүхий дулааны шугам сүлжээний засвар хийгдэж дууссан. Баянтал сумын эмнэлгийн байрны хөрөнгө оруулалтын төсөв энэ онд батлагдаж ирээгүй учраас хийгдээгүй   | 30.0 |

|    |  |  |      |
|----|--|--|------|
| 47 | 2.3.8. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулан, эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөнийг эрчимжүүлж, хамралтыг нэмэгдүүлэн дархлаажуулалтыг 99 хувьд хүргэнэ.           | Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох эрүүл аж төрөхөсыг хэвшүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудын дунд “Эрүүл мэндийг дэмжигч хамт олон шалгаруулах болзол журмыг боловсруулан дүгнэсэнээр 2008 онд 3 эрүүл мэндийг дэмжигч хамт олон байгууллага бий болсон ба энэ онд мөн дээрхи ажлыг үргэлжлүүлэн явуулж байна. Байгууллагууд дээр нийгмийн эрүүл мэндийн сайн дурын ажилтнуудыг бэлтгэн өгч ажиллуулж байна. Байгууллага хамт олныг өөрсдийн хүчээр биеийн тамир чийрэгжүүлэлтийн танхим, талбай, байгуулах санаачилгыг өрнүүлэн ажиллаж байна. 0-5 насны хүүхдийн дархлаажуулалт 99 хувьд хүрч тарилгатай халдварт өвчин гараагүй. Засгийн газрын 5-р тогтоолын дагуу АЗД-ын захирамж гарч хөдөлгөөн эрүүл мэнд уриан дор аж ахуйн нэгж байгууллагууд сар болгон нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулдаг болж энэ арга хэмжээ хэвшсэн. Долоо хоногийн Мягмар гаригийг автомашингүй алхалтын өдөр болгож хэвшүүлэх талын арга хэмжээ авч байна.  | 50.0 |
| 48 | 2.3.9. Ахмадуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулж, гэрээр үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.  | Ахмадуудад үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг чанаржуулж гэрээр үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар аймаг, сум, өрхийн эмнэлгүүд идэвхи санаачилгатай ажиллаж байгаа ба аймгийн Нэгдсэн эмнэлэг ахмад настнуудыг ээлж дараалалгүй хэвтүүлэн эмчлэх зорилгоор ахмадын тасгийг нээж тохижуулж, Уламжлалт бариа заслын эмчийг ахмадын хороонд гэрээгээр ажиллуулж байна. Гэрээр эмчилгээ шаардлагатай ахмад настныг тухай бүрд нь эмнэлгийн тусламжийг шуурхай үзүүлж хэвшсэн.  | 30.0 |
| 49 | 2.3.10. Эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах, тэдний нийгмийн баталгааг сайжруулан Баянталд 9, Сүмбэр суманд 15 айлын орон сууц ашиглалтанд оруулна. | Сүмбэр суманд 15, Баянтал суманд 30 айлын орон сууцыг ашиглалтад оруулж төрийн албан хаагчид, эмч эмнэлэгийн ажилчдыг байраар хангаад байна.   | 50.0 |
| 50 | 2.3.11. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх ёс, зан үйлийг хэвшүүлэхэд нийтийн биеийн тамирыг чиглүүлнэ.   | “Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх хянах хөтөлбөр”-ийн хүрээнд нийтийн биеийн тамирын арга хэмжээг аймгийн БТСХороотой хамтран явуулж хэвшээд байна . Аж ахуйн нэгж байгууллагуудад ажлын байранд хийх дасгал хөдөлгөөний ач холбогдлыг сурталчлан зааж сургаж, байгууллага хамт олныг өөрсдийн хүчээр биеийн тамир чийрэгжүүлэлтийн танхим, талбай, байгуулах санаачилгыг өрнүүлэн ажиллаж байна. МУЗГ-ын “Нийтийн биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээний тухай”2009 оны 5-р тогтоолын дагуу Аймгийн засаг даргын А/57 тоот захирамжийг гарган аж ахуйн нэгж байгууллагууд сар болгон тодорхой сэдвийн дор нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион явуулж байна. Мөн “Биеийн тамир-Эрүүл мэнд” уриан дор зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө болон хариуцан ажиллах байгууллагуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг АЗД-ын А/109 захирамжаар байгуулан ажиллуулав. Үүний үр дүнд жил ирэх тутам хүн амын өвчлөл нас баралт буурах үзүүлэлттэй гарч жилийн хүн амын цэвэр өсөлт 2.3 хувь,дундаж наслалт 69 байна. Нийтийн биеийн тамирын 38 арга хэмжээг 12 төрлөөр зохион явуулж давхардсан тоогоор 11500 хүнийг хамруулсан байна. 12 байгууллагын 185 хүн спортын заал танхимыг гэрээгээр ашиглан байгууллага хамт олноороо хичээллэж байна. | 50.0 |
| 51 | 2.3.12. Эм, эмийн санд тавих хяналтыг сайжруулна.  | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага үүсгэн байгуулах санаачилгыг дэмжин ажилласанаар одоогийн байдлаар эмийн сан 5 ажиллаж байна.Тус эмийн сангуудад Эрүүл мэндийн багц хуулиуд,түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журамыг үндэслэн, эмийн сангуудад тусгай зөвшөөрөл олгосон байдал, эдгээр эмийн сангуудад Эрүүлийг хамгаалах технологи эмийн сангийн бүтэц үйл ажиллагаа 5260:2006 стандарт болон бусад холбогдох  | 50.0 |

|                             |   |  |      |
|-----------------------------|---|--|------|
|                             |   | шийдвэрүүдийн хэрэгжилтийн шалгалтыг МХГ, ЭМГ-тай хамтран явуулж байгаа ба хууль зөрчсөн үйл ажиллагаа гараагүй. Эмийн сангууд нь үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон, улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаажилттай эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчилж байна. Эмнэлэг эмийн сангийн хооронд үүссэн өр авлага байхгүй.   |      |
| 52                          | 2.3.13. Хөдөөгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг тогтмолжуулж, шаардлагатай арга хэмжээг авахад нь дэмжлэг үзүүлэн унаатай болгоно.   | Нүүдлийн амбулаторийг 8 удаа зохион байгуулж 2006 км зам туулан хөдөөгийн 286 өрхийн 904 хүн амд үйлчлэн эрүүл мэндийн үйлчилгээг хүргэсэн. Багийн бага эмчийн тоог нэмэгдүүлэх, унаатай болох асуудлыг Эрүүл мэндийн газрын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаад байна. Тогтвортой амьжиргаа төслийн олон нийтийн санаачилгын сангийн төслөөр Баянтал сумын багийн эмчийг мотоциклоор, мөн ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар Сүмбэр сумын 6-р багийн эмчийг мотоциклоор хангаад байна.  | 50.0 |
| 53                          | 2.3.14. Тив, дэлхийн болон олимпид амжилт гаргах спортын төрлийг түлхүү хөгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын дэргэдэх спортын шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж, улс, бүсийн чанартай волейболын тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулна | Орон нутгийн уламжлал, онцлог, хүүхэд залуусын сонирхол, материаллаг бааз, боловсон хүчний нөөц, ирээдүйн хөгжлийн чиг хандлага зэргийг харгалзан түлхүү хөгжүүлэх спортын төрлөөр бокс, волейбол, чөлөөт бөх, талбайн теннис, жүдо бөх зэрэг төрлүүдийг сонгон хөгжүүлэх бодлого барин ажиллаж байна. Эдгээр спортын төрлүүдийн багш дасгалжуулагчдын мэдлэг мэргэшил, заах арга ур чадварыг дээшлүүлэх зорилгоор БТСУХороо, МҮОХ, спортын хороодоос зохион байгуулж буй сургалтанд хамруулсан болно.<br>Бүс улсын чанартай 28 спортын 10 төрлөөр оролцож 45 медаль авсан ба спортын мастер 3, дэд мастер 12,1-р зэргийн тамирчин 24 шинээр төрсөн байна.Бали аралд болсон элсний волейболын Азийн тоглолтонд А.Намуун оролцож боксын тамирчин Мөнхбаатар оюутны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль, Э.Эрдэнэхүү монгол туургатан хүүхдийн спортын наадмаас хүрэл медаль хүртэж, Турк улсад зохиогдох шатрын тэмцээнд Э.Түвшинтөгс оролцож байна. Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг волейбол,бокс,чөлөөт бөх, талбайн теннисний төрлөөр байгуулан 46 өсвөрийн тамирчид бэлтгэл сургуулилтаа тотмол хийж байна. | 50.0 |
| 54                          | 2.3.15. Биеийн тамир, спортын хорооны барилгыг өргөтгөж усан бассейн, чийрэгжүүлэлтийн танхимтай болгож, үндэсний болон чөлөөт бөхийн дэвжээг шинэчилнэ.  | Аймгийг хөгжүүлэх 2010 оны үндсэн чиглэлд оруулж байгаа болно<br>Хугацаа болоогүй  |      |
| 4. Нийгмийн халамж, даатгал |   |  |      |
| 55                          | 2.4.1 Иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэх санаачлагыг дэмжин ажил идэвхитэй эрж байгаа хүн ам болон эмзэг бүлгийн хүмүүст мэргэжил эзэмшүүлэх, давтан сургах, суурь үйлчилгээг тэгш хүртээх замаар хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, ядуурлаас хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.    | Тайлант хугацааны эхэнд 113 ажилгүйчүүд байснаас 1028 хүн шинээр бүртгэгдэж 52 хүн бусад шалтгаанаар хасагдаж 932 хүн сул чөлөөлөгдсөн ажлын байранд зуучлагдан хугацааны эцэст 157 ажилгүйчүүд буюу ажилгүйдлийн түвшин 3.5 болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.7 хувиар өссөн нь хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо өссөн, хүн амын хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдэж Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажигүйчүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.<br>168 хүнийг мэргэжил олгох сургалтанд хамруулан Экскваторчин, гагнуурчин, автосасварчин, үсчин, тогооч, шатахуун түгээгч зэрэг мэргэжил олголоо. Энэхүү үйлчилгээнд 17.8 сая төгрөг зарцуулсан байна<br>Нийтийг хамарсан ажлыг 33 удаа зохион байгуулж 716 хүнийг түр ажлын байраар хангасан.  | 50.0 |

|    |   |  |      |
|----|---|--|------|
|    |   | <p>36 ажил олгогчийг дэмжиж ажилласан.</p> <p>Италийн төрийн бус байгууллага АЙФО, Европын холбоо хамтран хэрэгжүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд нь сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэнийг мэргэжилтэй болгох зорилгоор Улаанбаатар хотын Сэргээн засалтын үндэсний төвтэй хамтран Ортопедийн техникч, тогооч, цэцэрлэгчийн мэргэжил эзэмшүүлж, зээлийн эргэлтийн сангаас зээл олгон ажлын байраар хангав. Аймгийн хэмжээнд 73 өрхийг сонгон өрхүүдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх үйлчилгээнд хамруулан амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Үүнээс 23 өрхийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулан хөдөлмөр эрхлэх төслийг дэмжин 2500.0 төгрөгийн тусламж олгон өрхийн аж ахуй эрхлүүлж байна. Бүлгүүд хоол цай зарах, дугуй нөхөх, гар утас засварлах, шүрэн эдлэл хийх, гахай үржүүлэх, оёдол хийх, ногоо тариалах зэрэг ажил үйлчилгээ эрхэлж байна.</p> |      |
| 56 | 2.4.2. Жижиг, дунд үйлдвэрлэл , үйлчилгээг хөгжүүлж, ажилгүйдлыг бууруулах олон талт арга хэмжээг хэрэгжүүлж 800 хүнийг ажлын байраар ханган 2012 он гэхэд хүн амын ажилгүйдлын төвшинг 3.0 хувьд хүргэнэ.                            | <p>ХААН,ХАС,Монгол Шуудан банкаар дамжуулан ХЭДС-ийн зээл,Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээл,жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих зээл болон улсын төсөв, хувь хүний хөрөнгөөр 383 ажлын байр шинээр бий болсон. Үүний 293 нь байнгын ажлын байр байна. Шинэ ажлын байр бий болгоход 747413.0 мянган төгрөгийн зээл олгогдсон байна. Үүнд:-ХЭДС-ийн зээлээр байнгын 57 ажлын байр,хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих зээлээр 34,жижиг зээлээр 52 иргэн зээл авч үйлдвэрлэл үйлчилгээ явуулж байна.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээгээр улирлын чанартай 90 ажлын байр,аж ахуй нэгж байгууллага хувь хүмүүсийн хөрөнгөөр шинэ байнгын ажлын байр 150 тус тус бий болсон байна. 33 удаагийн нийтийг хамарсан ажлыг 3 сумын ЗДТГ, ХХҮХ, НДХ, Цагдаагийн хэлтэс, Холбооны газар, Ус-ду, Тохижилт Сүмбэр,СӨХ,цэцэрлэг, сургуулиудтай гэрээ хийж зохион байгуулан 716 иргэнийг түр ажлын байраар хангав.</p>   | 50.0 |
| 57 | 2.4.3. Байгууллага бүхэн ахмадын сантай болж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.   | <p>Аж ахуй нэгж байгууллага бүр Ахмадын сан байгуулан ахмадынхаа нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэх эхлэл тавигдаж байна.</p>  | 30.0 |
| 58 | 2.4.4. Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх, нийгэм хамт олонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэмэгдүүлж хуульд заасны дагуу албан газар, аж ахуй нэгжүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах арга хэмжээ авна. | <p>Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн хамгаалалын ажлын хүрээнд нийгмийн халамжийн сангаас 97520.5 мянган төгрөгийн хөнгөлөлт үйлчилгээг үзүүлсэн байна.ХХҮХ-ийн дэргэд ахмадын өдөр өнжүүлэх болон чийрэгжүүлэлтийн танхим тогтмол ажиллаж үйл ажиллагаа нь жигдрээд байна.Аймгийн хэмжээнд 25-аас дээш ажиллагсадтай нийт 12 аж ахуйн нэгж буюу 1417 ажиллагсдад 52 иргэн ажиллуулахаас 22 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна.6 аж ахуйн нэгж хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй байгаа тул төлбөр төлүүлэх талаар шаардахад хөрөнгө байхгүйн улмаас зогсоод байна. Цаашид уг иргэдийг ажиллуулах буюу нөхөн төлбөр төлүүлэх тал дээр анхаарч ажиллах болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулсан нэг ажил олгогчийн урамшуулалд 500.0 мянган төгрөг зарцуулаад байгаа ба 11 иргэнийг байнгын ажлын байранд зуучлаад байна.</p>  | 50.0 |
| 59 | 2.4.5. “Тогтвортой амьжиргаа II” төслийн хүрээнд бэлчээрийн мал аж ахуй, эрсдэлийн удирдлага, олон нийтийн санаачлага сан, бичил санхүүгийн хөгжил гэсэн 3 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэйгээр үйл ажиллагааг өргөжүүлнэ.                 | <p>Олон нийтийн санаачилга сан бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд суурь боловсролыг дэмжих чиглэлээр -3,сургуулийн өмнөх боловсролыг дэмжих чиглэлээр-4,эрүүл мэндийг дэмжих чиглэлээр-4,дэд бүтцийг дэмжих чиглэлээр-3,нийтийн эзэмшлийн номын санг дэмжих-1,нийтийн эзэмшлийн биеийн тамир тоглоомын талбайг дэмжих чиглэлээр 1 бүгд 16 төслийг 69.4 сая төгрөгийн өртөгтэй хэрэгжүүлж байна. Үүний 8 төсөл нь хэрэгжиж дууссан ба 8 төсөл нь хэрэгжих шатандаа явж байна.Бэлчээрийн мал аж ахуй эрсдлийн удирдлага</p>   | 90.0 |

|  |  |  |      |
|--|--|--|------|
|  |  | бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд сумдын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгасан 25 төслийг хэрэгжүүлэхээр батлуулснаас худалдан авах ажиллагааны үр дүнгээр бэлчээр хаших, худаг ус засварлах, ХАА-н тоног төхөөрөмж авах, далан цөөрөм байгуулах, булгийн эх хаших, вакцинжуулалтын хашаа бэлтгэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх малчдын сайн дурын 23 бүлэгт 67.1 сая төгрөгийн , Сүмбэр сумын 5,6-р багийн нутагт байрлах өвс тэжээлийн агуулахын 3 барилгыг засварлах төсөлд 23.2 сая төгрөгийн бүгд 90.3 сая төгрөгийн санхүүжилт хийж төслүүд хэрэгжих шатандаа байна. Хэрэгжиж байгаа төслүүдийн нийт хөрөнгө оруулалтын 5-17.6 хувийг иргэд, олон нийтийн хандиваар 5-12 хувийг орон нутгийн байгууллага төсвөөс, 85-90 хувийг Тогтвортой амьжиргаа-2 төслөөс санхүүжүүлж байна. Төслийн үйл ажиллагааг иргэд олон нийтэд таниулах 1 сарын аяныг зохион байгуулж хэвлэл мэдээллийн хэрэгсэл, уулзалт, өдөрлөг, цэнгүүн, тэмцээн уралдаан зэрэг төрөл бүрийн хэлбэрээр төслийн үйл ажиллагааг сурталчилсан болно. |      |
| 60   | 2.4.6. Дэлхийн зөн ОУ-ын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр хүчирхийллийн эсрэг төв байгуулна.   | Хүчирхийллийн эсрэг төв байгуулах саналыг Дэлхийн зөн Олон улсын байгууллагад тавьсан.   |      |
| 61   | 2.4.7. Дайнд оролцсон ахмадуудыг орон сууцаар хангаж, өндөр настан, оюутан, сурагчдад хотын дотор зорчих унааны хөнгөлөлт үзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ   | Дайнд оролцсон ахмадуудыг орон сууцаар хангах журмын дагуу 8 ахмадын материалыг НХХЯаманд хүргүүлээд байна.  | 10.0 |
| <b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД</b>                                     |  |  |      |
| <b>ЗОРИЛТ: Үйлдвэрлэл хөрөнгө оруулалтыг ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлнэ.</b> |  |  |      |
| 1. Санхүү эдийн засгийн бодлого  |  |  |      |
| 62   | 3.1.1. Татварын бааз, суурийг өргөтгөж, санхүүгийн ажилтнуудын ёс зүйн хариуцлага, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын сахилгыг сайжруулж, урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшүүлэн, эдгээрт тавих хяналтыг чангатгана. | 2009 онд татварын бааз 14 ААНэгж, авто тээврийн улсын үзлэгийн үр дүнд 287 иргэнээр нэмэгдсэн.<br>Засаг даргын нэрэмжит зөвлөн туслах шалгалтыг төвлөрсөн төсвийн 18 нь байгууллагад хийж төсвийн зарцуулалт, төлөвлөлт, санхүүгийн ажилтаны ажлын хариуцлагыг шалгаж заавар зөвлөгөө өгч 2,8 сая төгрөгийн акт тавьсан.<br>Төсвийн газруудын нягтлан бодогч нартай гэрээ байгуулсан, төрийн сангаас олгож байгаа санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.<br>Хөрөнгө оруулалтыг тэргүүлэх чиглэлээр эрэмбэлэн, аймгийн 2009 оны үндсэн чиглэлд тусган АИТХ-аар зарцуулах хөрөнгийг батлуулан гүйцэтгэлд байнга хяналт тавьж ажиллаж байна.  | 30.0 |
| 63   | 3.1.2. Аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлж, улсын дунджид ойртуулна. (2007 оны байдлаар аймагт 974.1 мян.төгрөг, Улс 1742.8 мян.төгрөг).  | 2008 оны байдлаар аймгийн нэг хүнд ногдох ДНБ 190.3 мянган төгрөг болж 2007 оноос 45.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний гол шалтгаан нь судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо 2007 онд 110 байсан бол 2008 онд 132 болж өссөн үнийн инфляцын өсөлт зэрэг нөлөөлсөн.  | 30.0 |
| 64   | 3.1.3. Банкны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн шинэ бүтээгдэхүүнээр үйлчилэхэд дэмжлэг үзүүлж, Хонхор хотхонд банкны шинэ барилга ашиглалтад оруулна.  | Аймгийн хэмжээнд 5 арилжааны банк /ХААН, Хас, Монгол шуудан, Хадгаламж, Кредит/ үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс<br>ХААН банк нь Банк-Санхүүгийн салбарт сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох интернэт, мобайл, мессеж банкны үйлчилгээг нэвтрүүлж, Чойр өртөөний үйлчилгээний төвд 24 цагийн АТМ /бэлэн мөнгөний машин ажиллах, программын шинэчлэл хийн 2009 оны 5 сараас "ВТМ-2000" программыг ашиглаж эхэлсэн байна.  | 50.0 |

|                         |   |   |      |
|-------------------------|---|---|------|
|                         |   | <p>Мөн Хас банк нь гар утасны тусламжтайгаар бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоо хийх шинэлэг үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.</p> <p>Монгол шуудан банкны хувьд Шунхлай ХХК-тай хамтран шатахууны виза картыг зах зээлд нэвтрүүлсэн, мөнгөн гуйвуулгыг дэлхийн аль ч орноос 5 минутын дотор хүлээн авах – MONEY GRAM үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж, ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл /1% хүүтэй, 2 жилийн хугацаатай / олгож байна.</p> <p>Хонхор хотхоны 1-р байранд ХАС банкны салбар нээгдсэн, ХААН банкны байр 7-р сард ашиглалтад орно.</p> <p>Хас, ХААН, Монгол шуудан банкууд нь гурвалсан гэрээ байгуулснаар иргэдэд “өргүй” бичгийн тодорхойлолт өгөхөд хураамж / 1000 төг/ авахгүй болсон байна.</p>                            |      |
| 65                      | 3.1.4. Орон нутагт гаалийн салбар нээж, үйлдвэр, аж ахуйн үйл ажиллагааг нь дэмжиж, бүс нутагт бизнес эрхлэлтийн таатай нөхцлийг бий болгож, мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх орчинг бүрдүүлнэ.  | <p>Нийт 17 Аж ахуйн нэгж хайлуур жонш, 3 төрлийн /хүрэн болон чулуун, кокосжсон/ нүүрсийг ОХУ болон Хятад улсруу экспортолж байна Говь-Урал ХХК гаалийн хяналтын бүс байгуулж байгаа нь төмөр зам дагуу ачаагаа замбараагүй буулгах явдлыг зогсоож , гаалийн хяналт тавих нөхцлийг сайн бүрдүүлж байна. Орон нутагтаа гаалийн салбар байгуулснаар ААНэгжүүд Дорноговь аймгийн Айраг сумруу явж гаалийн бүрдүүлэлт хийдэг байсан зардал, цаг хугацааг нь хэмнэн бизнесийн үйл ажиллагааг нь дэмжиж, гаалийн бүрдүүлэлт болон гаалийн татварын гадагшлах мөнгөний урсгалыг орон нутагтаа төвлөрүүлэх болсон байна. Мөн Говийн аймгуудыг нефтийн бүтээгдэхүүнээр хангах импортын барааг орон нутагтаа хүлээн авдаг болсон.</p>               | 50.0 |
| 2.Жижиг дунд үйлдвэрлэл |   |   |      |
| 66                      | 3.2.1 Шивээ-Овоогийн нүүрсний орд газрыг түшиглэн цахилгаан станц, нүүрс химийн гүний боловсруулалтын үйлдвэр барих, Чойрын чөлөөт бүс, үйлдвэр-мэдээлэл технологийн парк байгуулах асуудлаар холбогдох газруудтай хамтран ажлыг эрчимжүүлнэ, Шивээ-Овоогийн нүүрсний орд газрын нарийвчилсан судалгааг хийлгэнэ. | <p>Чойр эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэр технологийн паркийн мастер төлөвлөгөөг Мон-Инжэкон ХХК-аар гүйцэтгүүлээд байна.</p> <p>Баянтал суманд Чойр эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэр технологийн паркийн эзэмшил 1300 га газрын асуудлыг шийдэж, 2009 оны төсөвт чөлөөт бүсийн конторын барилгын засварт зориулж 5.0 сая төгрөг батлуулсан. Чойр эдийн засгийн чөлөөт бүсийн үйлдвэр технологийн паркийн мастер төлөвлөгөөнд аймгийн онцлогтой уялдан байгуулах үйлдвэрүүдийн санал боловсруулж тусгууллаа.</p>   | 30.0 |
| 67                      | 3.2.2.Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүртээмж, үр дүнг сайжруулах чиглэлээр банктай гэрээ байгуулан зээлийн эх үүсвэрийг зүй зохистой хувиарлан үр дүнг тооцон, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавина.                                       | <p>Аймгийн эдийн засгийн нөөц боломж, бизнес орчны судалгааны үндсэн дээр Орон нутагт нэн тэргүүн ээлжинд дэмжин хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрийн чиглэлийг боловсруулан ХХААХҮЯ-аар батлуулав.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас зарласан Үйлдвэржүүлэлтийг дэмжих жилийн хүрээнд аймгийн ЖДҮДС-нд энэ онд 782 сая төгрөг төвлөрүүлэн 63 төсөлд 727.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. Зээлийн хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээлийн талаарх сурталчилгааг үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөн, Нээлттэй хаалганы өдөрлөг, багийн өдөрлөг, орон нутгийн сонин, мэдээллийн самбараар тогтмол хийж байна. Улсын Жижиг дунд үйлдвэрийн газраас зээлийн зүй зохистой хуваарилалтад шалгалт хийж сайн үнэлгээ өгөв.</p> | 50.0 |
| 68                      | 3.2.3. Хөнгөн, хүнсний үйлдвэр, барилгын материалын үйлдвэрийг дэмжиж, нэр төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.  | <p>Жижиг дунд үйлдвэрийг дэмжих дэд сангаас 2009 онд худалдаа үйлчилгээний 20, ахуй үйлчилгээний 12, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 15, хөнгөн үйлдвэрлэлийн 7, барилгын материалын 4, хүнсний үйлдвэрлэлийн 5, эм биобэлдмэлийн 1, нийт 64 төсөлд 727.6 сая</p>  | 50.0 |

|   |  |  |      |
|---|--|--|------|
|   |  | төгрөгийн зээл олголоо.<br>Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэлд мах, сүү боловсруулах үйлдвэрүүд байгуулах тухай тусгаж энэ хүрээнд Францын хүнсний сангийн төслийн хөрөнгөөр сүү боловсруулах чиглэлээр 2 хоршоонд 20.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгуулав.  |      |
| 59  | 3.2.4. “Нэг баг – нэг шилдэг бүтээгдэхүүн” хөдөлгөөн өрнүүлж, баг бүр Брэнд бүтээгдэхүүнтэй болно.   | “Нэг суурин - нэг бүтээгдэхүүн” дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн брэнд бараа, үйлчилгээг бий болгох зорилгоор сум, аймаг, бүсийн хэмжээнд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж үзэсгэлэн худалдаанд оролцож шилдгээр шалгарсан иргэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, үйлдвэрлэлийг тогтмолжуулах, өргөжүүлэх бодлого барьж байна.<br>Аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газар, Мерси Кор Монгол олон улсын байгууллагатай хамтран "Говьсүмбэр-2009" үзэсгэлэн худалдааг 2009 оны 9-р сарын 25, 26-ны өдрүүдэд Сүмбэр сумын төвд амжилттай зохион байгууллаа. Энэ жилийн үзэсгэлэн худалдаанд орон нутгийн 84 бизнес эрхлэгч, малчид бараа бүтээгдэхүүнээрээ худалдаанд оролцож, нийт үзэсгэлэн худалдааны борлуулалтын орлого 49 сая төгрөг болсон байна. Өмнөх жилүүдтэй харьцуулахад орон нутагт үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүний тоо нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна. Үзэсгэлэн худалдааны үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 1585.0 мянган төгрөг зарцууллаа. Говьсүмбэр-2009 үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүнийг 7 нэр төрлөөр шалгаруулсан бөгөөд аймгийн брэнд бүтээгдэхүүнээр Шивээ-Овоогийн хүрэн нүүрс шалгарсан. Түүнчлэн аймаг, сумдын брэнд мал амьтан шалгаруулав.<br>Сүмбэр сум “Хөх хуц”, Баянтал сум “Тахиа”, Шивээговь сум “хүрэн нүүрс”-ээр тус тус бренд бүтээгдэхүүнээ тодорхойлж, аймгийн бренд | 70.0 |
| 70  | 3.2.5. Баянтал суманд тоосгоны, Шивээговь суманд жонш баяжуулах үйлдвэр байгуулан мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, байгаль экологийн сөрөг нөлөөгүй орчин үеийн техник, технологи ашиглахад анхаарна  | Аймгийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас Барилгын материалын үйлдвэрлэх 4 аж ахуй нэгжид зээл олгон барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж ажилласнаар жилдээ 12000 м <sup>2</sup> замын хавтан, 24000 үнсэн блок үйлдвэрлэх хүчин чадал бүхий үнсэн блокны үйлдвэр, вакум цонхны үйлдвэрүүд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Тус үйлдвэрүүд орон нутагт хийгдэж буй зам талбай, барилгын ажлыг тус аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлж байна.<br>Баянтал суманд тоосго, блокны үйлдвэр байгуулахаар иргэн Лхагвасүрэнгийн төслөө хийгээд байна.  | 50.0 |
| <b>ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХҮЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ</b>  |  |  |      |
| <b>ЗОРИЛТ: Өндөр ашиг шимт мал, аж ахуй, өрхийн тариаланг дэмжиж хүн амыг аюулгүй хүнсээр хангана</b> |  |  |      |
| 71  | 4.1.1. Сүмбэр каракуль хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөн сүргийн зөв бүтцэд оруулж, төрийн хамгаалалтад авч, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болгон бодлогын яам, агентлагтай хамтран ажиллаж богино хугацаанд үр дүнд хүргэнэ | “Сүмбэр” үүлдрийн хонины цөм сүрэг, түүний удмын санг хамгаалах, тоо толгойг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн өмчит “Цөм сүргийн үржлийн төв” байгуулан ажиллуулж байна.<br>Орон нутгийн өмчит цөм сүргийн үржлийн төв нь эрчимжсэн мал аж ахуй эрхэлж каракуль хонь өсгөн үржүүлэх чиглэлээр аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 10 сая төгрөг, ХХААХҮЯамнаас 6.0 сая нийт 16 сая төгрөгийн зээл авч үржлийн 287 эм хонь худалдан авч Сүмбэр үүлдрийн хуцаар цус шингээх эрлийзжүүлэг явуулж байна. Мөн зохиомол хээлтүүлгийн гэр фүнкүт худалдан авч нийт 504 малд зохиомол хээлтүүлэг хийлээ.  | 50.0 |



|    |  |  |      |
|----|--|--|------|
|    |  | <p>Тус төв энэ онд 100 эхээс 75 төл бойжуулан 258 каракуль арьс бэлтгэн орон нутгийн орлогод 5 сая 620 мянган төгрөгийн орлого оруулаад байна. Цөм сүргийн үржилд ашиглаж байгаа нийт хээлтэгч, хээлтүүлэгч малд 7мал эмнэлэг эрүүл мэндийн үзлэг хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулан, үржлийн анхан шатны бүртгэл хөтлөн баталгаажуулаад байна.</p> <p>Хөдөөгийн малчдад эрчимжсэн мал аж ахуй эрхэлж малын үүлдэр угсааг сайжруулах, өндөр ашиг шимт мал өсгөн үржүүлэх талаар арга зүйн зөвлөмж өгч “Сүмбэр хонь” үүлдрийн хээлтүүлэгч мал худалдан авах захиалга авч үржлийн өсвөр насны хээлтүүлэгч 10-г худалдан борлуулах болоод байна. Цөм сүргээс бойжуулсан 96 каракуль хурганд ангилалт хийж бүртгэлжүүлээд байна.</p>  |      |
| 72 | 4.1.2 Мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээг стандартын төвшинд хүргэж итгэмжлэгдсэн лабораторитой болно.   | <p>2009 онд халдварт өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 108.3 мянган мал буюу 88.5%, угаалганд 32.3 мянган мал буюу 53.8%, туулга боловсруулалтанд 62 мянган мал буюу 61.4% хамрагдаж шөвөг яр, дотрын халдварт хордлого, цусан халдвараас хамгаалах вакцинууд 100% таригдсан.</p> <p>Лабораторийн шинжилгээнд 3.6 мянган мал хамрагдаад байна 36.4 мянган м<sup>2</sup> талбайн малын хашаа, хороо, агуулах, бэлчээрийн талбай, сэг зэмийг халдваргүйжүүлсэн . Мал эмнэлгийн лабораторийг итгэмжлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.</p>  | 30.0 |
| 73 | 4.1.3 Атрын 3-р аяны хүрээнд төмс, хүнсний ногоо тариалж өөрсдийн хэрэгцээг ханган, өрхийн тариалан, малын тэжээл бэлтгэн усалгаатай тариалан хөгжүүлж, усалгаатай талбайн хэмжээг 50- 70 га-д хүргэн, хүн амын төмс, хүнсний ногооны нийт хэрэгцээний 70 орчим хувийг болон шаардлагатай өвс, тэжээлийнхээ 20 хуртэл хувийг өөрсдөө тариалж бэлтгэнэ. | <p>2009 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар 80 га талбайг тариалангийн зориулалтаар олгоод байгаа бөгөөд 32 га-д тариалалт хийсэн нь талбай ашиглалт 2008 оны мөн үеийнхээс 28 %-иар нэмэгдээд байна.</p> <p>Монгол улсад газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 50 жилийн ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар сумдын ЗДТГ-т заавар зөвлөгөө өгч энэ дагуу сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан комисс ажиллаж байна. Ойн ажлын хүрээнд усалгаатай талбайн хэмжээг өмнөх оноос 1.5 дахин нэмэгдүүлэх замаар төмс хүнсний ногооны хангамжийг 25, таримал тэжээлийн хангамжийг 20-с доошгүй хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 22 га-д төмс хүнсний ногоо, 18 га-д тэжээлийн ургамал тариалаад байна. Газар тариалангийн салбарт 37 түр ажлын байр бий болоод байна.</p> <p>Таримал ургамлын нэр төрлийг олшруулах зорилгоор ХХААХҮЯамнаас шинээр 2 төрлийн таримлын үр 6 тоннын авсан бөгөөд 7 га-д хөх тариа туршилтын журмаар тариалж байна.</p> | 50.0 |
| 74 | 4.1.4. Хоршиж хамтрах замаар бэлчээрийг нөхөн сэргээх, хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах, малын тэжээлийн ургамал тариалах ажлыг урамшуулан дэмжиж, хөтөлбөр төсөлд хамруулна.   | <p>Малчдын бүлэг хоршоо шинээр 20 орчим байгуулагдсан бөгөөд бүх суманд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. ТА II төслийн Бэлчээрийн МАА эрсдлийн удирдлага төслийн газарт хоршиж хамтрах замаар бэлчээрийг нөхөн сэргээх, хашиж хамгаалах, ойн зурвас байгуулах, малын тэжээлийн ургамал тариалах 27 төсөл дэмжигдээд байна.</p>   | 50.0 |
| 75 | 4.1.5. Төмс, хүнсний ногоо, махны зоорийн аж ахуйг хөгжүүлэн, хоршоо, нөхөрлөл, бүлгийг урамшуулан дэмжиж хүн амын хүнсний хэрэгцээний 30-аас доошгүй хувийг зоорийн аж ахуйгаас хангана.  | <p>Засгийн газрын “Агропарк” төслийн хүрээнд улсын төсвийн 29,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Шивээговь, Баянтал, Сүмбэр сумдад 30тн багтаамжтай зоорь, бага оврын трактор, худаг, хүлэмж бүхий иж бүрэн агропарк байгуулагдсан. Энэ онд сумдын агропаркууд нийт 360 м<sup>2</sup> талбай бүхий хүлэмжинд тариалалт хийж 1.66 тн төмс, 2.35 тн хүнсний ногоо иргэдэд борлуулсан байна.</p> <p>Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэлд төмс хүнсний ногоо, зоорийн аж ахуй хөгжүүлэх талаар тусган энэ чиглэлээр ирүүлсэн 2 төсөлд жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 29.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Зоорийн аж ахуйг хөгжүүлэх, зоорь барих үүсгэл санаачилгыг дэмжих зорилгоор “Зоорь-2009” уралдаан зарлан аж ахуйн нэгж,</p>   | 50.0 |

|    |   |   |      |
|----|---|---|------|
|    |   | иргэнийг шагнаж урамшууллаа.  |      |
| 76 | 4.1.6. Хүнсний аюулгүй байдлыг хангахад холбогдох байгууллагуудын үйл ажиллагаагаа чиглүүлнэ. | Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Иод дутлын эмгэгтэй тэмцэх ” аймгийн дэд хөтөлбөр боловсруулж ИТХ-р батлуулахаар хүргүүлээд байна. “Хүнсний баталгаат байдал” аймгийн дэд хөтөлбөрийг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулан боловсруулж байна. | 30.0 |
| 77 | 4.1.7. Эрчимжсэн мал аж ахуй болон гахай, шувууны аж ахуйг эрчимтэй хөгжүүлнэ.                | Гахай, тахианы аж ахуй эрхлэхийг дэмжиж аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 4 төсөлд 45.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.   | 30.0 |

**ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО**

**ЗОРИЛТ:** Байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангаж, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

|    |   |   |      |
|----|---|---|------|
| 78 | 5.1.1. Цөлжилтийн үйл явцад дүн шинжилгээ хийж мэдээллийн санг бүрдүүлж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бэлчээрийг сэргээх зөв зохистой ашиглах бодлого баримтлан, орон нутагт “Элс”, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.  | <p>УЦУОШАлбаны судалгаагаар сүүлийн жилүүдэд манай аймгийн агаарын температур дунджаар 0.8 хэм дулаарч хур тунадасны хэмжээ 8 мм –ээр буурч, 15 м/с-ээс дээш хурдтай шороон шуургатай өдрийн тоо өсч, бэлчээрийн ургац 2-3 ц/га–аар буурсан үзүүлэлттэй байна. “Сүмбэр бороо 1” экспедиц 5 сараас хойш үйл ажиллагаагаа явуулснаас хойш хур тунадасны хэмжээ эрс нэмэгдэж бэлчээрийн ургамлын ургалт 1.5 ц/га-аар нэмэгдэж, ургамалын дундаж өндөр 20 см хүрч зуншлагын байдал сайжирсан.</p> <p>Аймгийн хэмжээнд “Цөлжилт”-ийн мэдээллийн санг үүсгэж 2003-2009 оны бэлчээрийн даац, ургамалын судалгаа, Сүмбэр сумын элжсэн талбайн судалгааны материалуудыг оруулсан. Мөн 9-р сард МУИС-ийн багш нараар аймгийн хэмжээний хөрс, ургамалын судалгааг хийлгүүлсэн.</p> <p>Малчдаас нийт 48 га бэлчээрийг хашиж хамгаалах олон наст ургамалын үр цацаж сэргээх зорилгоор 13 төсөл боловсруулан “Тогтвортой-Амьжиргаа-II” төслөөр дэмжүүлэн хэрэгжүүлж байна.</p> <p>Орон нутгийн онцлогтой уялдуулан “Элс” хөтөлбөр санаачлан энэ хүрээнд Сүмбэр сумын 2-р багийн гэр хорооллын хамгийн хойд талын Чойр, Малчин, Шивээ, Өгөөмөрийн эгнээний хуралдсан 2000 тн, Сүмбэр сумын ЗДТГ-ын хашааны эргэн тойрны 200 тн шуурсан элсийг зайлуулж цэвэрлэсэн. Энэ ажилд “Архидалт, ажилгүйдэл, Хог хаягдлыг бууруулах” хөтөлбөрийн хөрөнгөөс 1.8 сая төгрөг зарцуулсан. Мөн аймгийн төв талбайн өргөтгөлийн ажилд 1500 тн элс зөөвөрлөн ашигласан.</p> <p>Цөлжилтийг сааруулах бэлчээрийг хамгаалах, зүй зохистой ашиглах үүднээс Сүмбэр сумын хэмжээнд “Бэлчээр ашиглалтын журам”-ыг сумын ИТХ-ын 46 тоот тогтоолоор батлуулан мөрдөж ажиллаж байна.</p> | 30.0 |
| 79 | 5.1.2. Мод сөөг үржүүлэх санал, санаачлагыг дэмжиж, нийтээр мод тарих хөдөлгөөн өрнүүлэн мод үржүүлгийн газартай болж, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж., гол усны эх, замын дагуу ойн зурвас бий болгоно. | <p>Энэ онд МСҮТ сургалтын төв БОАЖЯ-наас мод үржүүлгийн газар байгуулах 4230.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан бөгөөд Сүмбэр суманд үр мөчрийн эх цэцэрлэгийн болон тарьц суулгац үржүүлгийн 0.5 га талбайд 10000 гаруй тарьц ургуулах бэлтгэл хангагдсан. Үржүүлгийн энэ талбайд олон наст өвсний ботууль, биелэг зэрэг 5 төрлийн үрийг тариалж үр авах боломжийг судалж байна. Шивээговь сумын Хаялага нуурыг түшиглэн 5 га газрыг бойжуулгын талбай болгож хайлаас, буйлс, сухай, жигд агч, бургасны бүгд 2600 ш мод сөөг тариалсан. /Санхүүжилтийн 50 хувийг 4-р сард олгон, гүйцэтгэлийг 11 сард хүлээн авч</p>  | 50.0 |

|    |  |   |      |
|----|--|---|------|
|    |  | <p>үлдсэн 50 хувийг оноос өмнө олгохоор шийдвэрлэсэн./</p> <p>БОАЖСайдын албан даалгаврын дагуу 2009 оны 4 сарын 25-наас 5-р сарын 25-ны өдрүүдэд “Бүх нийтээр мод тарих” сарын аяныг зохион байгуулж хайлаас, улиас, шар хуайс, чацаргана, голтбор, саваа мод, усан бургас, мөнгөлөг улиас 3182, “Чойр эко парк” төслийн хүрээнд 8000 гаруй модыг нөхөн тарилтаар нэмж тарьсан. 10 сард аймгийн хэмжээнд ургаж буй модны тооллого явуулахад Шивээговь сум 4 төрлийн 655 мод, Баянтал сум 3 төрлийн 401 мод, Сүмбэр сум 9 төрлийн 2767, Чойр эко парк төслийн 28224 мод, нийт 32057 мод ургаж байгааг тооллоо.</p> <p>Мөн ХХҮХ-тэй хамтран “Цэцэрлэгт хүрээлэн” төсөл хэрэгжүүлж төмөр замын зам дагуух сааданд 60 хайлаасны мод тарьж 10 хүнийг түр ажлын байраар хангасан. Энэ ажилд 1 сая төгрөг зарцуулав.</p> <p>Авто замын дагуу ойн зурвас байгуулахад шаардагдах хөрөнгийг ирэх оны төсөвт тусгах талаар холбогдох байгууллагуудад санал тавиад байна.</p>  |      |
| 80 | 5.1.3 Усны нөөцийн тооллого явуулж ширгэж байгаа гол горхи, булаг шандын эх, баян бүрдийг хамгаалах, ан агнуурын зохион байгуулалтын судалгаа гаргаж зохистой ашиглан, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангана. | <p>Аймгийн хэмжээнд гадаргын усны тоо бүртгэлийг 10 сарын 27-ноос 11 сарын 10-ны хугацаанд хийлээ. 2009 оны тооллогоор аймгийн хэмжээнд 5 гол, 2 рашаан, 6 булаг, цоонг 11, нуур тойром 7, баянбүрд 1, 272 худаг уст цэг тоологдлоо.</p> <p>Аймгийн Засаг даргын А/160 тоот захирамжаар Гүн шанд, Өгөөмөрийн голын эхийг хашиж хамгаалах ажлын үнэлгээний хороог томилон тендер шалгаруулалт явуулж “Чойр-Оргил” хоршоогоор ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Гүн шандын эхэнд 0.35 /50*70/ га талбайг хашаажуулсан, Өгөөмөрийн голын эхэнд 90*40 хэмжээтэй талбайг хашаажуулсан. Мөн малчид Тогтвортой –Амьжиргаа-II төслийн газар 3 булаг шандыг тохижуулж мод бут тарих төслөө хийж хүргүүлэн хэрэгжих шатандаа байна.</p>   | 50.0 |
| 81 | 5.1.4. “Хурын шим “Төвийн салбарыг байгуулж, бэлчээрийн МАА-н эрсдлийг бууруулж, ган зудын давтамжийг багасгана.   | <p>“Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2015 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн УЦУОША үүлэнд зориудаар нөлөөлөх экспедицийн судалгаа шинжилгээний иж бүрэн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангагдаж 5 сараас үйл ажиллагаагаа эхэлсэн. Тус экспедиц Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нутагт хөрсний чийгийг дэмжих, хур тунадас нэмэгдүүлэх зорилгоор давхардсан тоогоор 20 удаа ажиллаж нийт 43 пуужин харвасан. Үүний үр дүнд 5-р сард 1.6 мм, 6-р сард 12.9 мм, 7 сард 168.9 мм тунадас орсон байна.</p>   | 70.0 |
| 82 | 5.1.5. Хог хөтөлбөр боловсруулан төв, суурин газруудын туурь, балгасыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулж , устгал хийдэг байгууламжтай болно.  | <p>Аймгийн Засаг даргын 2009 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/87 тоот захирамжаар “Цэвэр хоггүй амьдарцгаая” аяныг 2009 оны 3-р сарын 28-ны өдрөөс 5-р сарын 8-ны өдрүүдэд зохион байгуулан ажилласан. Аяны хүрээнд 4-р сарын 5-нд хатуу хучилттай авто замын 2 талыг хамарсан 500 га талбайн гялгар уут хог хаягдлыг цэвэрлэх ажлыг аж ахуйн нэгж албан байгууллагуудын 923 ажилчдыг оролцуулан цэвэрлэж, 27 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэлээ. Хатуу хучилттай замын хажуу карьерийн дагуу 2 га талбайг хамарсан барилгын хог хаягдлыг түрж тэгшлэн эрүүлжүүлсэн. Намрын байгаль хамгаалах өдрүүдийн хүрээнд 10-р сарын 17-ны өдөр нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж, 1500 гаруй иргэн хамрагдаж албан байгууллага, оршин суугаа газрынхаа ойр орчимд цэвэрлэгээг хийсэн. Шивээговь сумын хэмжээнд 6-р сарын 10-13-ны өдрүүдэд барилгын туурь хог хаягдалтай талбайг ААН-үүдэд хуваарилан өгч нийтийн их цэвэрлэгээг өрнүүлэн 9-10-р байрны зүүн талын 3489 м<sup>2</sup> талбайд хуримтлагдсан барилгын туурь 5467 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргэсэн.</p> | 30.0 |
| 83 | 5.1.6 Чойрын богд уулыг улсын тусгай хамгаалалтанд авч, аргалын сүргийн тоо толгойг  | <p>Чойрын Богд уулыг улсын тусгай хамгаалалтанд оруулах судалгаа шинжилгээний ажил бүрэн хийгдэж Байгаль Орчны ямаар дэмжигдэн УИХ-д хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд</p>   | 50.0 |

|  |   |   |      |
|--|---|---|------|
|  | өсгөж түүхэн болон байгалийн цогцолбор газар болгож, тохижуулалтыг үе шаттайгаар хийнэ.   | оруулсан.<br>2009 оны 2-р сараас эхлэн Сүмбэр, Шивээговь сумдад орон тооны байгаль хамгаалагч авч ажиллуулж, байгаль хамгаалагчдыг хувцас, дуран, цахилгаан бороохой, БОАЖЯамны хөрөнгөөр унаажуулсан. /мотоцикл/<br>2-3-р сард аргаль хонины идэш хоолонд зориулж өвс тавьж өгч биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ ажилд 1.5 сая төгрөг зарцуулсан.<br>10-р сард биотехнологийн хүрээлэн, БОАЖЯ-тай хамтран аргаль хонины тооллого явуулахад 150 гаруй аргаль хонь тоологдож 2007 оныхтой харьцуулахад 80 толгойгоор өссөн байна.   |      |
| 84   | 5.1.7 Сумдыг орон тооны байгаль хамгаалагчтай болгож, унаа, техник хэрэгсэлээр хангана.   | 2009 оны 2-р сараас эхлэн Сүмбэр, Шивээговь сумдад орон тооны байгаль хамгаалагч авч ажиллуулж, байгаль хамгаалагчдыг хувцас, дуран, цахилгаан бороохой, унаагаар /мотоцикл/ хангасан.<br>Мөн Сүмбэр суманд 2 гэрээт байгаль хамгаалагч ажиллуулж, хувцас, дурангаар хангасан.  | 90.0 |
| 85   | 5.1.8.Сумдын төвийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийлгэж, иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж, цэг тэмдэгтийн мэдээллийн сантай болно.   | Сумдын газар зохион байгуулалтын 2009 оны төлөвлөгөөнд иргэн бүрт олгох газрын хэмжээ байршлыг тогтоож, төлөвлөгөөны дагуу иргэдэд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд өссөн дүнгээр 1655 иргэнд 306.45 га газрыг өмчлүүлээд байна. Газар өмчлүүлэх ажил 12.9 хувьтай байна.<br><br>Төмөр замын дагуу байрлах улсын нэгдсэн тогтолцоонд холбогдсон 67 цэг,GPS-ийн сүлжээний Сүмбэр суманд 5. Баянтал Шивээговьд тус бүр 2 цэгийн мэдээллийг бүрдүүлээд байна.   | 50.0 |
| 86   | 5.1.9.Хувийн хэвшилд тулгуурласан аялал жуулчлалын үйлчилгээг дэмжинэ.  | Аймгийн хэмжээнд иргэд олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, орон нутгийн түүх соёлын дурсгалт газруудыг танин мэдүүлэх, байгаль орчноо хамгаалах зорилгоор “Чандмань эрдэнийн эрэлд” тойрон аялал, “Эрүүл амралт” дугуйн аялалыг зохион байгуулж 30 гаран хүнийг хамрууллаа.<br>2009 оны 12 сарын 4-6-нд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Mongolia ITF-2009” Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аймгаа төлөөлөн оролцлоо. Тус үзэсгэлэн худалдаанд гадаад дотоодын аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг 130 гаруй байгууллага оролцож өөрийн орны болон аймгийн аялал жуулчлалын үйлчилгээ, урлаг соёл, гар урлалын үйлдвэрлэлийг сурталчилсан. Манай аймгаас БОАЖГ, “Боржигин өв ” музей, Чойр урлан ХХКомпани хамтран амжилттай оролцлоо.<br>Аялал жуулчлалын бааз байгуулах санаачилга гаргасан иргэн одоогоор байхгүй байна. | 30.0 |
| <b>ЗУРГАА. ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ</b>   |   |   |      |
| <b>ЗОРИЛТ:</b> Дэд бүтцийн салбаруудын уялдаа холбоог сайжруулж, орон нутгийн хөгжлийг хангахад чиглүүлнэ. |   |   |      |
| 87   | 6.1.1. Баянтал, Шивээговь сумын дулаан, Баянтал сумын цахилгаан, цэвэрлэх байгууламжийн асуудлыг иж бүрнээр нь шийдвэрлэж, Сүмбэр сумын төв зууханд өргөтгөл хийж, цэвэр, бохирын шугамыг нэгдсэн сүлжээнд холбоно. | Баянтал сумын уурын зуухны засварын ажлыг орон нутгийн төсвийн 50.0 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж ашиглалтад хүлээн авсан. Орон нутгийн төсвийн 74.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий ИШС-ний ажлыг Гурван Хажинга компаниар гүйцэтгүүлээ. Шивээговь сумын уурын зуухны засварын ажлын гүйцэтгэгчээр “Хоризонт сервис” ХХК ажиллаж ашиглалтанд оруулсан.<br>Баянтал сумын уурын зуухны тэжээл болох 6/0.4 кв-ын агаарын шугам шинээр барих, трансфоматорын дэд өртөө шилжүүлэн угсрах ажлыг “ Боржигон хүч” ХХК-аар гүйцэтгүүлж   | 70.0 |

|    |   |  |      |
|----|---|--|------|
|    |   | ашиглалтанд хүлээлгэн өгсөн.   |      |
| 88 | 6.1.2. Засгийн газрын Орон сууц хөтөлбөрийн хүрээнд Шивээговь суманд 150, Сүмбэр суманд 200, Баянтал 150 айлын сууц засварлан орон сууцны фондыг нэмэгдүүлнэ.                             | МУЗГ-ын “ 40000 орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Сүмбэр суманд 80 айлын орон сууцыг улсын комисс хүлээн авч ашиглалтанд орууллаа. Баянтал сумын 75 айлын орон сууцыг засварлан ашиглалтанд авахад бэлэн болоод байна.Шивээговь суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 30 айлын орон сууц засварлагдаж байна.   | 70.0 |
| 89 | 6.1.3. Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын усан сангуудыг эрүүл ахуйн стандартад нийцүүлж, алслагдсан гэр хорооллын усан хангамж, гэрэлтүүлгийн асуудлыг үе шаттай шийднэ.                   | Усан сангуудын ариутгал цэвэрлэгээг бүрэн хийсэн. Хонхор хотхон болон гэр хорооллын 56 гэрлийн шонд урсгал засвар хийсэн. Гэр хорооллыг төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд холбох саналыг НААҮ-г хөгжүүлэх 2010 төсөлд тавьж шийдүүлсэн. Мөн Хот байгуулалтын салбарын МОН-2301 төслөөр гэр хорооллын усан хангамжийг сайжруулах ажлыг шийдүүлэхээр болоод байна.                                | 30.0 |
| 90 | 6.1.4. Аймгийн төвийн хатуу хучилттай авто болон явган хүний замыг уртасгаж, Шивээговь сумын төвийг босоо тэнхлэгийн авто замтай холбож, аймаг, сумын төв талбайг өргөтгөн шинээр барих.  | Аймгийн төвийн авто замын дагуух явган хүний замыг өргөтгөх ажил төсөвт өртөг өндөр гарсан тул ажил хийгдээгүй хүлээгдэж байна. Сүмбэр сумын төв талбай өргөтгөлийн ажлыг орон нутгийн төсвийн 27.3 сая төгрөгийн хөрөнгөөр 1500 м <sup>2</sup> талбайг хийж ашиглалтад хүлээн авсан. Шивээговь сумыг босоо тэнхлэгийн хар замтай холбох саналыг Улсын авто замын газарт албан бичиг хүргүүлсэн. | 50.0 |
| 91 | 6.1.5. Катв-ийн цэгийн тоог 1200-д хүргэж,1.5 км-ээс цааш ажиллах өндөр хурдны интернетийн үйлчилгээг нэвтрүүлж, шуудангийн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.                          | Катв-ийн цэгийн тоо 1200-д хүрч, 1.5 км-ээс цааш ажиллах өндөр хурдны интернетийн үйлчилгээг нэвтрүүлсэн.  | 70.0 |
| 92 | 6.1.6. Сүмбэр суманд босоо тэнхлэгийн авто замын дагуу транзит тээврийн авто үйлчилгээний цогцолбор төвийг байгуулна.   | Авто техник үйлчилгээний цогцолбор төв байгуулахаар аймгийн төвд 2 га газар авсан. Тээврийн хэрэгслийн оношлогоо хяналт зохицуулалтын газар байгуулагдан 10 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. “Сүмбэр айраг” ХХК газар тариалангийн техник тоног төхөөрөмжийн засварын төвийг байгуулан үйлчилгээ эрхэлж байна.  | 50.0 |
| 93 | 6.1.7. Авто замын хөрөнгөөр Сүмбэр сумын III багийн доторх замыг шинэчилж ,төв суурин газрын гэрэлтүүлгийг шийдвэрлэнэ.   | Аймгийн авто замын сангийн 40 сая төгрөгийн хөрөнгөөр 2.2 км замын дагуу гэрэлтүүлэгийн ажлыг гүйцэтгүүлэв. Тохижилт Сүмбэр компанитай гэрээ байгуулан авто замын арчилгааг 4.8 сая төгрөгөөр хийлгэн 2 хүнийг ажлын байраар хангасан.   | 50.0 |
| 94 | 6.1.8. Хонхорын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангаж бэлтгэл тэжээлийн шугамтай болгоно.  | Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй<br>Хугацаа болоогүй   | 0    |
| 95 | 6.1.9 . Гэрлэх ёслолын өргөө, ахмадын ордонтой болно  | Гэрлэх ёслолын өргөө, ахмадын ордны зураг төсөв, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох газруудад танилцуулж байна.   | 10.0 |
| 96 | 6.1.10. “Тохижилт-Сүмбэр” компаний хүчин чадлыг нэмэгдүүлж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.   | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлээр “Тохижилт-Сүмбэр” компанид хог зөөвөрлөх 1 машин авч нийт 3 машинаар үйлчилгээ үзүүлж тээвэрлэсэн хогийн хэмжээ өмнөх оноос 1.2 дахин нэмэгдсэн байна. Ус-Ду ХХК-аас универсаль трактор авч техник тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээ авлаа.  | 50.0 |
| 97 | 6.4.11. Хот хоорондын, хотын доторхи нийтийн тээвэр, шуудангийн үйлчилгээг хамгийн тохиромжтой хэлбэрээр шийдвэрлэж, авто машины талбайг шинээр байгуулж, шинэлэг үйлчилгээг бий болгоно. | Аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 10 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр “Нийтийн тээвэр” төслийг дэмжсэнээр хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээ тогтмолжлоо. Хот хооронд явдаг 30 таксиг нэгтгэн хоршоо байгуулан таксины зогсоолын газрыг шийдвэрлэж өгөв.   | 50.0 |

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2008-2012 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2009-12-11

Чойр хот

| Д/д  | Арга хэмжээний тоо | Үүнээс        |                        |     |     |     |     | Хугацаа болоогүй | Тасарсан             |                                  | БИЕЛЭЛТИЙН ДҮН / хувь / |
|------|--------------------|---------------|------------------------|-----|-----|-----|-----|------------------|----------------------|----------------------------------|-------------------------|
|      |                    | Биелсэн /100/ | Хэрэгжих шатандаа /% / |     |     |     |     |                  | Зохион байгуулалтаас | Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас |                         |
|      |                    |               | 90%                    | 70% | 50% | 30% | 10% |                  |                      |                                  |                         |
| Бүгд | 97                 | -             | 2                      | 10  | 43  | 31  | 6   | 5                | -                    | -                                | 43.7                    |

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.ТӨВСАНАА